


ЖИЛИЙН ТАЙЛАН 2025/2026



АГУУЛГА

● Бүлэг 1 Удиртгал

- 5 Өмнөх үг
- 6 Бидний тухай
- 8 Стратеги 2030
- 10 Бидний үзүүлдэг үйлчилгээ
- 11 Бидний ажилладаг голлох салбар
- 12 IRIM тоогоор
- 13 Гишүүнчлэл, хамтын ажиллагаа

● Бүлэг 2 IRIM 2025 онд

- 16 2025 оны онцлох ажлууд
- 18 2025 оны үйл явдлын товчоон
- 20 2025 онд гаргасан нээлттэй тайлангууд

● Бүлэг 3 2025 онд хэрэгжүүлсэн төслүүд

IRIM-ийн санаачлан хэрэгжүүлсэн төслүүд

- 22 Төрийн байгууллагын цахим ил тод байдлын индекс 2025
- 24 Азийн нийгмийн сайн сайхан байдлын үндэсний хэмжээний хоёр дахь судалгаа: Монгол Улс

Хэрэгжиж дууссан төслүүд

- 26 Тойрог эдийн засаг ба ногоон бизнесийн чиглэлд бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг чадавхжуулах зөвлөх үйлчилгээ
- 28 Монгол Улсад уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох талаарх мэдлэг, хандлага, дадлын судалгаа
- 30 “Цахим хоршоо” төслийн суурь судалгаа
- 32 Нийтийн цахим дэд бүтцийн нэвтрүүлэлт дэх хүртээмжийг хэмжих нь” судалгааны мэдээлэл цуглуулалт
- 34 “Skillshift mongolia” төслийн суурь судалгаа
- 36 НҮБ-ын хүүхдийн сангийн WASH хөтөлбөрийн эцсийн үнэлгээний мэдээлэл цуглуулах төсөл
- 38 “Тэгш хүртээмжтэй эрчим хүчний шилжилтийн хүрээ”-г боловсруулах зөвлөх үйлчилгээ
- 41 Залуучуудын сургуулиас хөдөлмөрийн зах зээл рүү шилжих шилжилтийн судалгаа
- 42 “Монгол Улс дахь жендэр-смарт бизнесүүдийг дэмжих нь” туршилтын төсөл

Хэрэгжиж буй төслүүд

- 44 “Уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах болон жендэрийн мэдрэмжтэй бодлогоор дамжуулан хөдөөгийн эмэгтэйчүүд, охидын жендэрийн тэгш байдлыг сайжруулах нь” техник туслалцааны төсөл
- 46 “Хуурамч мэдээлэлтэй тэмцэх замаар ардчилал, шударга ёсыг бэхжүүлэх нь” төсөл
- 50 Гэр бүлд ээлтэй ажлын байрны бодлогын хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдлын судалгаа
- 52 Сонгинохайрхан болон Баянзүрх дүүргийн олон нийтийн хэрэгцээг тодорхойлох судалгаа
- 54 Агаарын бохирдлыг бууруулах боломж, үр нөлөөний судалгаа
- 56 “Төр-Хувийн хэвшил-Малчдын түншлэл-2026”

IRIM судалгааны хүрээлэн



Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
6-р хороо, 301, Бага тойруу, 301 14200



46A/265 Монгол, Улаанбаатар



www.irim.mn



IRIMongolia



irim_mongolia



irim_mongolia



+976-7011-7101



contact@irim.mn

ННА 60
ДАА 300
Ж-705

ISBN 978-9919-0-6555-3

БҮЛЭГ 1

Удиртгал

Өмнөх үг

Бидний тухай

Стратеги 2030

Бидний үзүүлдэг үйлчилгээ

Бидний ажилладаг голлох салбар

Гишүүнчлэл, хамтын ажиллагаа

ӨМНӨХ ҮГ

2025 он хөгжлийн салбарын хувьд олон хүчин зүйлсийн огтлолцол гүнзгийрсэн, илүү төвөгтэй, тодорхойгүй орчинд шилжсэн жил байлаа. Уур амьсгалын өөрчлөлт, эрчим хүчний шилжилт, дижитал технологийн хурдацтай хөгжлүүд харилцан уялдаатайгаар өрнөж, бодлого тодорхойлогчид болон институтийн чадавхыг шинэ түвшинд сорьж байна. Үүний зэрэгцээ олон улсын хамтын ажиллагаа, тогтвортой хөгжилд зориулах хүчин чармайлт хумигдсан нь хамтын шийдэл боловсруулах боломжийг мөн хязгаарлах боллоо.

Эдгээр нөхцөл байдал нь ардчиллын үнэт зүйлс, хүний эрх, олон нийтийн итгэлцэлд нөлөөлж, ялангуяа худал, ташаа мэдээллийн тархалт нь бодлогын чанар, нийгмийн тогтвортой байдалд бодитой эрсдэлүүдийг учруулах болжээ. Энэ нь Монгол Улсын хувьд ч үндэсний бодлого, шийдвэр гаргалтад шууд нөлөөлж буй бодит нөхцөл болж, хөгжлийн бодлогыг илүү бие даасан, урт хугацааны ашиг сонирхолд нийцүүлэн тодорхойлох шаардлага улам бүр тодорхой болж байна.

IRIM судалгааны хүрээлэнгийн хувьд бид энэ өөрчлөгдөж буй орчинд зөвхөн судалгаа гүйцэтгэгч бус, харин нотолгоонд суурилсан шийдлийг тодорхойлох, бодлогын хэлэлцүүлэгт чиглүүлэг өгөх институтийн үүргээ бэхжүүлэхэд анхааран ажиллаж байна. 2025 онд бид Монгол Улсын хөгжлийн бодлогод стратегийн ач холбогдолтой хэд хэдэн чиглэлд төвлөрөн ажиллалаа. Тухайлбал,

- Тэгш хүртээмжтэй эрчим хүчний шилжилтийн хүрээг боловсруулж, уур амьсгалын зорилт, эдийн засгийн хөгжил, нийгмийн хүртээмж хоорондын тэнцвэрийг хангах бодлогын шийдлүүдийг санал болгов.


- Хиймэл оюун ухааны бэлэн байдлын үнэлгээг гүйцэтгэж шинэ технологийн бодлогын суурийг бүрдүүлэв.
- Монгол Улс дахь хуурамч мэдээллийн орчны зураглалын судалгааг гүйцэтгэж олон нийтийн итгэлцэл, мэдээллийн орчны эмзэг байдал, засаглалын чанарт үзүүлж буй нөлөөллийг илүү нарийвчлан ойлгох суурийг бүрдүүллээ.

Эдгээр ажил нь зөвхөн судалгааны үр дүнгээр хязгаарлагдахгүй, бодлогын хэлэлцүүлэгт ашиглагдаж, шийдвэр гаргалтад нөлөөлөхүйц мэдлэгийн бүтээгдэхүүн болж байна.

Бид нотолгоонд суурилсан, мэргэжлийн судалгаагаар талуудын итгэлийг үргэлжлүүлэн хангахыг эрхэмлэж, ISO 9001:2015 чанарын удирдлагын тогтолцоо болон ISO 20252:2019 судалгаа, өгөгдлийн олон улсын шаардлагыг үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлж, судалгааны бүх үе шатанд чанар, ил тод байдал, ёс зүйн шаардлагыг институцийн түвшинд баталгаажуулж байна.

Цаашид ч тодорхойгүй байдал давамгайлах хөгжлийн салбарт найдвартай өгөгдөл, хараат бус шинжилгээ нь шийдвэр гаргалтын суурь хэвээр байх болно. Иймд бид 2026 оныг хиймэл оюуны шийдлүүдийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, судалгааны чадавх, бүтээмжээ нэмэгдүүлэх замаар нотолгоог бодит шийдэл, нөлөөлөл болгоход хувь нэмрээ оруулах зорилт тавин эрч хүчтэйгээр жилээ эхлүүлээд байна.

Бидэнд бүх цаг үед итгэл хүлээлгэн хамтран ажилладаг хамтрагч, харилцагч байгууллагууд болон хамт олондоо чин сэтгэлийн талархал илэрхийлье.



БИДНИЙ ТУХАЙ

2008

Монгол Улсын судалгааны салбар дахь хараат бус зарчмыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор их сургуулийн хоёр багш, хоёр шавь хамтран IRIM судалгааны хүрээлэнг 2008 онд хамтран үүсгэн байгуулсан.

2030

Бид үйл ажиллагаагаа 2030 он хүртэлх стратегийнхаа хүрээнд "Тогтвортой хөгжлийн зорилт 2030"-тай уялдуулж, бүс нутгийн болон үндэсний тогтвортой хөгжлийг ахиулахад бодит хувь нэмэр оруулж байна.

30

Бид Засаглал, Уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой байдал, Нийгэм, эдийн засаг, хөгжил, Дижитал технологи ба инновац гэсэн үндсэн дөрвөн хөтөлбөрийн баг, түүн дотроо судалгаа, төслийн менежментэд мэргэшсэн 30 орчим үндсэн ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

12

Бид одоогоор Зүүн Өмнөд болон Төв Азийн 12 улсад хөгжлийн болон зөвлөх үйлчилгээний төслүүд хэрэгжүүлж, олон улсын туршлага, үр нөлөөгөө нэмэгдүүлсээр байна.

300

Бид үндэсний болон олон улсын түвшний 300 гаруй гэрээт зөвлөх, судлаачидтай хамтран ажиллаж, тухайлсан салбар болон салбар дундын төслүүдийг мэргэжлийн, олон талт баг бүрэлдэхүүнтэйгээр хэрэгжүүлж байна.



Бид тогтвортой хөгжлийг дэмжих бодлого, шийдвэрүүдийг нотолгоонд суурилсан мэдээллээр хангаж, бодит өөрчлөлт, хэмжигдэхүйц үр нөлөөг бий болгоход чиглэсэн судалгаа, үнэлгээ, зөвлөх үйлчилгээний салбарт тэргүүлэгч байгууллага.

СТРАТЕГИ 2030

АЛСЫН ХАРАА

Бид мэдлэгийн төв, нийгмийн өөрчлөлтийг хөтлөгч байна.

БИДНИЙ ҮНЭТ ЗҮЙЛС



Хараат бус

Бид өөрсдийн үйл ажиллагааг аливаа шашин, улс төр, бизнесийн бүлгүүдээс ангид байлгахыг нэн тэргүүнд тавьдаг. Үүнийг хангахын тулд бид өөрсдийн мэдээллийг ил тод байлгаж, тогтмол хөндлөнгийн аудит хийлгэдэг.



Чанар

Бид байгууллагынхаа бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг хангах зорилгоор байгууллагын (ISO9001:2015) чанарын бодлогыг тасралтгүй хэрэгжүүлж, түүний дагуу сайжруулах арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлдэг.



Үр нөлөө

Бид хэрэгжүүлж буй үйл ажиллагаагаараа дамжуулж улс орон, бүс нутгийн нэн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах, эерэг үр нөлөөг бий болгоход анхаарч ажилладаг.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Хэрэглэгчийн хэрэгцээнд нийцсэн, мэргэжлийн түвшний хараат бус бүтээгдэхүүн үйлчилгээгээ үзүүлж, тогтвортой хөгжилд хөтлөгч, тасралтгүй хөгжих мэдлэгийн төв байна.

IRIM СТРАТЕГИ



Үр нөлөөг дээшлүүлэх



Технологийн шинэчлэлийг нэвтрүүлсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх



Тогтмол хөгжих, тогтвортой хүний нөөцийг бүрдүүлэх.



Байгууллагын сайн засаглалыг бий болгох

ЧАНАРЫН БОДЛОГО



Олон улсын стандарт, захиалагчийн хэрэгцээнд нийцсэн, хараат бус судалгааны үйлчилгээ үзүүлдэг, тогтвортой хөгжих байгууллага байна.

БИДНИЙ ҮЗҮҮЛДЭГ ҮЙЛЧИЛГЭЭ

Судалгаа

Бид Олон Улсын Социологийн Холбооны "Ёс зүйн дүрэм", ISO стандартууд, судалгааны нийтлэг зарчмуудыг мөрдөж, шинжлэх ухаанч, шинэлэг арга зүйг ашигласан олон төрлийн судалгааны ажлуудыг гүйцэтгэдэг. Бид аливаа судалгааны төслүүддээ өгөгдөл мэдээллийн найдвартай байдалд онцгойлон анхаарч, хөгжлийн түншүүдийн шийдвэр гаргалтад зориулж орон нутгийн онцлогт нийцсэн, нийгмийн ялгаатай бүлгүүдийн дуу хоолойг тусгасан, чанартай нотолгоо бүрдүүлэхийг зорьдог.



Хяналт-шинжилгээ, үнэлгээ

Бид хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийн өөрчлөлтийн онол (Theory of Change), ХШҮ-ний хүрээ, индикатор боловсруулах зөвлөх үйлчилгээ үзүүлж, мөн холимог судалгааны аргуудыг ашиглан төслийн суурь, дунд шатны, эцсийн, үр нөлөөний цогц үнэлгээг гүйцэтгэдэг. Ингэж сайн туршлага, саад бэрхшээлүүдийг баримтжуулах, нотолгоонд суурилсан зөвлөмж боловсруулснаар цаашдын хөгжлийн санаачилгуудын үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулж байна.



Төслийн менежмент, зөвлөх үйлчилгээ

Бид төр, хувийн хэвшил, орон нутаг, олон улсын хөгжлийн байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор стратеги, менежментийн зөвлөх үйлчилгээг үзүүлэхээс гадна донор байгууллагуудын хөгжлийн төслүүдийн менежментийг хариуцах, чанарын өндөр түвшинд хэрэгжүүлэх, асуудлыг илрүүлж бодлогын шийдэл боловсруулах чиглэлд арвин туршлагатай.



Сургалт, хэлэлцүүлэг

Бид өөрсдийн мэргэшсэн салбар, үйл ажиллагааны хүрээнд аливаа байгууллага, хувь хүмүүсийн хэрэгцээнд нийцсэн цогц сургалтуудыг зохион байгуулдаг. Үүнээс гадна тодорхой нийгмийн бодлого, асуудлын хүрээнд олон улс, үндэсний хэмжээний болон байгууллагын түвшний хэлэлцүүлэг, чуулган, хурлуудыг олон талыг хамруулж, үр дүнд чиглэсэн, утга учиртай байдлаар, өндөр түвшинд зохион байгуулж байна.



БИДНИЙ АЖИЛЛАДАГ ГОЛЛОХ САЛБАР

Бид Засаглал, Нийгэм, эдийн засаг, хөгжил, Уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой байдал, Дижитал технологи ба инновац гэсэн салбаруудад голлон ажиллаж, Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдсан, нийгэмд эерэг нөлөө бүхий төслүүдийг амжилттай хэрэгжүүлж байна. Бидний хийж гүйцэтгэдэг судалгаа, шинжилгээ, зөвлөх үйлчилгээний ажлууд зөвхөн нэг салбараар хязгаарлагдахгүйгээр, салбар дундын асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэдэг нь манай үйл ажиллагааны гол онцлог юм.

Засаглал

Бид үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн засаглалын салбарт тогтвортой ажиллаж, нотолгоонд суурилсан судалгаа, шинжилгээгээр дамжуулан төрийн эгэх хариуцлага, ил тод байдал, шударга ёс, үр нөлөөтэй байдлыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулсаар байна. Бидний судалгааны үндсэн сэдвүүдэд төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, ил тод байдал, авлига, цахим засаглал, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, ардчилал, хүний эрх, иргэний орон зай зэрэг хамаарна.



Нийгэм, эдийн засаг, хөгжил

Бид хөгжлийн түншүүд, иргэний нийгэмтэй хамтран, хөгжлийн салбарын төвд ажиллаж, нийгмийн асуудлуудыг шийдвэрлэх, тэгш бус байдлыг бууруулахад шинжлэх ухаанд суурилсан нотолгоо, мэдээлэл бий болгож, туршилтын төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ирсэн. Боловсрол, жендэр, нийгмийн эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хот, хөдөөгийн хөгжил, хүртээмжтэй эдийн засаг, тогтвортой хөдөлмөр эрхлэлт зэрэг олон салбарт ажиллахдаа хөгжлөөс "хэнийг ч орхигдуулахгүй байх" зарчмыг эрхэмлэж, нийгмийн ялгаатай бүлгүүдийн дуу хоолойг шийдвэр гаргалтад тусгахыг зорьдог.



Уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой байдал

Бид уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй хөгжлийн төлөө хөдөө аж ахуй, уул уурхай, аялал жуулчлал, эрүүл мэнд зэрэг нийгмийн олон салбарт уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицоход чиглэсэн судалгаа, зөвлөх үйлчилгээг хийж гүйцэтгэж байна. Мөн байгаль хамгаалал, хариуцлагатай уул уурхай, тэгш хүртээмжтэй эрчим хүчний шилжилт, тогтвортой дэд бүтэц, тэдгээрийн орон нутгийн иргэдийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, сайн сайхан байдалд үзүүлэх нөлөөллийг судалж, тохиромжит шийдэл боловсруулахад анхаарч ажиллаж байна.



Дижитал технологи ба инновац

Бид дижитал дэд бүтэц, хиймэл оюуны хэрэглээний өнөөгийн нөхцөл байдал, эрсдэл, боломжийг судлан, бодит нотолгоонд суурилсан зөвлөмж, мэдлэгийг бүтээн ажиллаж байна. Энэ чиглэлийн ажлууд бидний хувьд шинэ тутам боловч нийгэмд үзүүлэх цаашдын үр нөлөөг нь харгалзан, үйл ажиллагааныхаа тэргүүлэх салбар болгож, дижитал технологийн хариуцлагатай засаглал, ил тод байдал, ёс зүйтэй хэрэглээ, хүртээмж, чадавх, аюулгүй байдлыг бий болгоход голлон анхаарч байна.



IRIM ТООГООР

НИЙТ
380
төсөл

2008 ОНЫ 4 сар 2026 ОНЫ 4 сар

252,960 Респондент 117 Захиалагч 165 Хамтрагч

Салбараар

111 Засаглал	46 Эдийн засаг, хөдөлмөр эрхлэлт	70 Уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой байдал	153 Нийгмийн хөгжил	167 Хяналт-шинжилгээ, үнэлгээ	158 Судалгаа	36 Төслийн менежмент	19 Сургалт
--------------	----------------------------------	--	---------------------	-------------------------------	--------------	----------------------	------------

Үйлчилгээний чиглэлээр

ГАЗАР ЗҮЙН ТҮРШЛАГА

Хэрэгжүүлсэн төслийн тоо

ТӨВ АЗИ

- 2 Афганистан
- 2 Казакстан
- 2 Киргизстан
- 1 Пакистан
- 1 Шри-Ланка
- 2 Тажикистан
- 1 Туркменистан
- 1 Узбекистан

МОНГОЛ

- | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
|-------------|---------------|---------------|-----------|---------------|---------------|---------------|-----------|--------------|-------------|-----------|----------|-------------|---------------|--------|--------------|------------|--------|---------|------------|-----------|-----------------|
| 56 Архангай | 50 Баян-Өлгий | 62 Баянхонгор | 36 Булган | 59 Говь-Алтай | 35 Говьсүмбэр | 66 Дархан-Уул | 61 Дорнод | 50 Дорноговь | 44 Дундговь | 58 Завхан | 47 Орхон | 78 Өмнөговь | 61 Өвөрхангай | 54 Увс | 45 Сүхбаатар | 62 Сэлэнгэ | 55 Төв | 79 Ховд | 68 Хөвсгөл | 56 Хэнтий | 236 Улаанбаатар |
|-------------|---------------|---------------|-----------|---------------|---------------|---------------|-----------|--------------|-------------|-----------|----------|-------------|---------------|--------|--------------|------------|--------|---------|------------|-----------|-----------------|

ЗҮҮН ӨМНӨД АЗИ

- 1 БНХАУ
- 1 Зүүн-Тимор
- 1 Бангладеш
- 1 Филиппин



ГИШҮҮНЧЛЭЛ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА

ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА

АКАДЕМИК БАЙГУУЛЛАГА

ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА

ХУВИЙН ХЭВШЛИЙН БАЙГУУЛЛАГА

ГИШҮҮНЧЛЭЛ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Гадаад



Бид 2022 оноос хойш Төв Азийн Бүс Нутгийн Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Институтийн Төв Азийн Тинк танк байгууллагуудын сүлжээнд элсэж, форум, хэлэлцүүлэгт тогтмол оролцох, хамтын санаачилгуудыг дэмжих замаар бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны талаарх цаг үеийн мэдлэгээ тасралтгүй нэмэгдүүлж байна.



IRIM судалгааны хүрээлэнгийн төлөөлөл 2020 оноос эхлэн Азийн Ардчиллын Судалгааны Сүлжээнд гишүүнээр орж, ардчиллын чиглэлээрх судалгааны үр дүнгээ олон улсад хуваалцах, хамтын ажиллагаа өрнүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллаж байна.



Бид АНУ-д төвтэй Give2Asia олон улсын хандивын сүлжээнд 2019 онд нэгдэн эрсэн ба уг сүлжээгээр дамжуулж 2020, 2021, 2024 онуудад орон нутгийн иргэдийг дэмжих төслүүдийг санаачлан, хэрэгжүүлсэн.



Бид 2018 оноос Innovation for Change Төв Азийн бүс нутгийн сүлжээнд нэгдэж, ТУЗ-ийн гишүүн байгууллагуудаар сонгогдсон. Одоогоор иргэний нийгмийн байгууллагуудын эрхийг хамгаалах, түүнд тулгарч буй бэрхшээлүүдийг даван туулах арга замыг бий болгох зорилго дор сүлжээний гишүүдтэй хамтран ажиллаж байна.



Бид 2016 оноос "Сайн сайхан байдлын судалгаа"-г жил бүр санаачлан хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд 2017 оны 10 дугаар сард "Нийгмийн сайн сайхан байдлын олон улсын консорциум"-д Монгол Улсыг төлөөлөн гишүүнээр нэгдэн орсон.



Бид 2016 онд Ази, Номхон Далайн Үнэлгээний Холбоонд гишүүнээр элсэн орж, 2017 оноос манай байгууллагын төлөөллүүд тус холбооны ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна. Холбоогоор дамжуулж үнэлгээний туршлага хуваалцаж, бүс нутгийн сайн туршлагыг идэвхтэй нэвтрүүлэх замаар Монгол Улсдаа болон бүс нутагтаа үнэлгээний дадлыг бэхжүүлэхэд хүчин чармайлт гаргаж байна.



Бид 2010 онд Олон Улсын Социологийн Холбоо (ISA)-нд албан ёсны гишүүнээр нэгдсэн ба холбооны чуулган, бага хурлуудад тогтмол оролцож, гүйцэтгэсэн судалгааны үр дүнгээ танилцуулан, хэлэлцүүлэг өрнүүлж, онолын болон арга зүйн мэдлэг, туршлагаа нэмэгдүүлсээр байна.



Ази, номхон далайн улс орнуудын "Нийгмийн хариуцлагын төлөөх 20 сүлжээ" байгууллагын гишүүнээр 2010 оноос хойш ажиллаж байна.

Дотоод



Монгол Улсын Жендэрийн Үндэсний Хорооны орон тооны гишүүнээр 2017 оноос ажиллаж байна. Энэ хүрээнд нийгмийн бүхий л салбарт жендэрийн тэгш эрхийг хангуулах, төрийн бодлогод жендэрийн тэгш эрхийн зарчмыг хангуулах тал дээр иргэний нийгэм, хувийн эвшлийг төлөөлөн ажиллаж байна.



IRIM судалгааны хүрээлэн нь Монголын Социологийн Холбоог 2024 оны 6 сард сэргээн байгуулснаас хойш төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна.



IRIM судалгааны хүрээлэнгийн төлөөлөл Иргэний нийгмийн консорциумын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, ИНБ-уудын эрх ашгийг хамгаалахад хувь нэмрээ оруулан ажиллаж байна.



Бид Монголын үнэлгээний сүлжээг байгуулах санаачилгыг 2016 онд эхлүүлсэн ба энэ чиглэлээр ажилладаг төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагын мэргэжилтэн, зөвлөхүүдийг эгнээндээ нэгтгэсэн. Одоогоор нарийн бичгийн үүрэг гүйцэтгэж байгаагийн хувиар Ази, номхон далайн бүсийн үнэлгээний стратеги болон олон улсын үнэлгээний стандартуудыг нэвтрүүлэх, түгээх үүрэгтэйгээр ажиллаж байна.




Бид уур амьсгалын чиглэлээр салбар бүрд хийгдэж буй судалгааны ажлуудыг уялдуулах, судлаач, мэргэжилтнүүдийн мэдээлэл солилцоог нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй хөгжлийн чиглэлээр "Мэргэжилтэн-судлаачдын бүлгэм/ Community of Practice"-ийг санаачлан байгуулсан. Уг бүлгэмээр дамжуулан улирал бүр уур амьсгалын салбарын судалгааны үр дүнг хэлэлцүүлж, шийдэлд чиглэсэн бодлогын хэлэлцүүлэг өрнүүлж байна.

БҮЛЭГ 2

IRIM 2025 онд

- 2025 оны онцлох ажлууд
- 2025 оны үйл явдлын товчоон
- 2025 онд гаргасан нээлттэй тайлангууд



2025 ОНЫ 4 сар
2026 ОНЫ 4 сар

12,847
Респондент

27
Захиалагч

4
Хамтрагч

Салбараар

4 ЗАСАГЛАЛ	6 ЭДИЙН ЗАСАГ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ	8 УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ, ТОГТВОРТОЙ БАЙДАЛ	10 НИЙГМИЙН ХӨГЖИЛ
----------------------	---	---	------------------------------

Үйлчилгээний чиглэлээр

3 ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ	16 СУДАЛГАА	8 ТӨСЛИЙН МЕНЕЖМЕНТ	1 СУРГАЛТ
---------------------------------------	-----------------------	-------------------------------	---------------------

2025 ОНЫ ОНЦЛОХ АЖЛУУД



Бүс нутгийн хамтын ажиллагаа, олон улсын туршлага

Бид 2025 онд олон улсын туршлага нэмж, "Хуурамч мэдээлэлтэй тэмцэх замаар ардчилал, шударга ёсыг бэхжүүлэх нь" төслийг Филиппин улсад хэрэгжүүлж байна. Мөн Гүйцэтгэх захирал Н.Минжирмаа Ази Номхон далайн Үнэлгээний холбоо (APEA)-ны Удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдож, IRIM судалгааны хүрээлэнгийн төлөөллүүд Олон улсын социологичдын холбоо, Азийн ардчиллын судалгааны сүлжээ, Нийгмийн сайн сайхан байдлын олон улсын консорциум, Innovation for Change сүлжээний хурал, хэлэлцүүлэгт судалгааны үр дүнгүүдээ танилцуулан, олон улсын хамтын ажиллагаагаа бататган, өргөжүүлээ.



Ажилтнуудын сайн сайхан байдал

Бид 2025 онд ажилтнуудынхаа сайн сайхан байдалд онцгой анхаарч, бүх ажилтнаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, гэр бүлд ээлтэй ажлын байрны бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд зайнаас болон хосолсон байдлаар ажиллах боломжийг нэмэгдүүллээ. Мөн хамт олныхоо сэтгэлзүйн болон биеийн эрүүл мэндийг дэмжих зорилгоор соёл, спортын нэгдсэн арга хэмжээг жилийн турш үе шаттайгаар зохион байгуулж, хамт олноороо Азийн улс орнуудаар аяллаа.



Мэдээллийн аюулгүй байдал

Бид 2025 онд байгууллагынхаа мэдээллийн аюулгүй байдлыг бэхжүүлэх, үйл ажиллагаагаа олон улсын сайн туршлагад нийцүүлэх зорилгоор үе шаттай ажлыг хэрэгжүүллээ. Үүнд, мэдээллийн аюулгүй байдлын дотоод дүрэм, журмаа сайжруулах, мэдээллийн аюулгүй байдлын сургалт, хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулах, мэдээллийн аюулгүй байдлын соёлыг бэхжүүлэхэд анхаарч, удирдлагын тогтолцоонд шинэ шатанд гаргасан.



Улирал бүрийн товхимол

Бид 2025 оны нэгдүгээр улирлаас эхлэн байгууллагынхаа хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, үзүүлж буй үр нөлөө, ахиц дэвшлээ нээлттэй мэдээлэх зорилгоор улирал тутмын товхимол (newsletter)-ыг монгол, англи хэл дээр гаргаж байна. Одоогийн байдлаар дөрвөн удаагийн товхимлыг 300 орчим харилцагч, хамтран ажиллагсдаа илгээж, олон нийтэд нээлттэй байршууллаа.



Дижитал шилжилт ба IRIM


Монгол Улсын Засгийн газар "Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратеги"-аа баталж, салбар бүрд дижитал шилжилтийг чухалчилсан 2025 онд IRIM ч энэхүү чиглэлд онцгойлон анхаарлаа. Тухайлбал, хиймэл оюун, нийтийн цахим дэд бүтцийн судалгаануудыг гүйцэтгэж, дижитал технологийн боломжийг нийгмийн сайн сайхны төлөө зориулахад идэвхтэй дэмжлэг үзүүлж, мөн байгууллагынхаа дотоод процессын үр ашгийг нэмэгдүүлэв.

2025 ОНЫ ҮЙЛ ЯВДЛЫН ТОВЧООН, САРААР



Бид “Хиймэл оюуны бэлэн байдлын үнэлгээ”-ний анхдугаар хэлэлцүүлгийг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр болон Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамтай хамтран зохион байгууллаа.

Бид 2025 оны 2-р сарын 5-7-ны өдрүүдэд Япон Улсын Токио хотод Нийгмийн сайн сайхан байдлыг судлах олон улсын консорциумын хуралд оролцлоо. Азийн 9 орны нийгмийн сайн сайхан байдлыг судалдаг эрдэмтэн, судлаачид цугларч хоёр өдрийн турш улс орны сайн сайхан байдлын асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлэв.



Байгууллагынхаа нийт ажилтнуудыг урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамрууллаа

Эрүүл ажилтан – Эрч хүчтэй байгууллага! Хамт олныхоо эрүүл мэнд, нийгмийн асуудлыг дэмжих ээлжит ажлын хүрээнд 2025 оны 03-р сард урьдчилан сэргийлэх үзлэг, цогц шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгууллаа.

ЖАЙКА-гийн захиалгаар хэрэгжүүлж буй “Жендэрт суурилсан хүчирхийллийн өнөөгийн нөхцөл байдал” сэдэвт судалгааны үр дүнгийн хэлэлцүүлэг зохион байгууллаа. Хэлэлцүүлгийн үеэр жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг гэр бүл төвтэй байдлаар, сургуулийн өмнөх боловсролоос эхлүүлж, иргэний мэдрэмж, хүний эрхийн ойлголт, хүчирхийллийг үл тэвчих хандлагыг хүүхдэд багаас нь төлөвшүүлэх шаардлагатайг онцоллоо.



“Жендэрийн тэгш байдал ба Уур амьсгалын өөрчлөлт” сэдэвт олон улсын хурал 5-р сарын 22, 23-нд зохион байгуулагдлаа. Хурлын үеэр олон улсын сайн туршлагыг солилцож, уур амьсгалын өөрчлөлтийн хариу арга хэмжээний чадавхыг бэхжүүлэх бодитой алхмуудыг хамтран тодорхойлж, хурлын үр дүнд Уриалгыг баталлаа. IRIM хурлын гол агуулгыг боловсруулахад зөвлөх үйлчилгээний хүрээнд хамтран ажиллав.



GGGI-ийн захиалгаар Монголд анх удаа хийгдсэн “Монгол дахь уур амьсгалын өөрчлөлтийн хүний эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал, хоол тэжээлд үзүүлэх нөлөөлөл”, “Уур амьсгалын өөрчлөлтөд эрүүл мэндийн байгууллагуудын бэлэн байдал, хариу арга хэмжээний чадавхыг үнэлэх судалгаа”-ны тайлангуудыг оролцогч талуудад танилцуулан, Эрүүл мэндийн яам болон Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд албан ёсоор хүлээлгэн өглөө.




Уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээрх “Мэргэжилтэн-судлаачдын бүлэг”-ийн гурав дахь уулзалт амжилттай боллоо. Энэ удаагийн уулзалтыг Green Dot Climate байгууллагатай хамтран “Уур амьсгалын өөрчлөлт ба залуучууд” сэдвийн хүрээнд зохион байгууллаа. Уулзалтад энэ чиглэлд судалгаа хийдэг, төсөл хэрэгжүүлдэг залуучуудын төлөөлөл оролцож, залуусын санал бодол, мэдлэг, хандлагын судалгааны үр дүнг танилцуулсан юм.

Зуны сургалтаа 17 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа. 2024 онд бид байгууллагын стратегиа шинэчилсэнтэй холбогдуулан энэ жилийн зуны сургалтаар стратегитайгаа уялдуулан байгууллагын ажилтнуудын болон компанийн алсын хараагаа хэрхэн харж байгаагаа хамтдаа хэлэлцлээ.



IRIM нь “Тэгш хүртээмжтэй эрчим хүчний шилжилтийг эрчимжүүлэх нь” НҮБ-ын хамтарсан хөтөлбөрийн зөвлөх багаар ажиллан цуврал хэлэлцүүлгүүдийг зохион байгууллаа. Үүний үр дүнд “Тэгш хүртээмжтэй эрчим хүчний шилжилтийн хүрээ”-г боловсруулан хүлээлгэн өгөв.

Боловсролын салбарын ажилтнууд ажил хаялт зарласантай холбогдуулан манай байгууллага ажил хаялт дуусах хүртэл бага насны хүүхэдтэй эцэг, эх асран хамгаалагч ажилтнуудаа зайнаас ажиллуулж, бусад байгууллагыг уриаллаа.



ЖИЛИЙН ХҮЛЭЭН АВАЛТ – 2025: ХӨГЖЛИЙН ИРЭЭДҮЙГ СУДАЛГААНЫ ӨНЦГӨӨС сэдвийн хүрээнд Жилийн хүлээн авалтын арга хэмжээгээ амжилттай зохион байгууллаа.



Оюутан залуусыг судалгааны үр чадварт сургах “Судлаач оюутан-2025” хөтөлбөр 12 дахь жилдээ амжилттай хэрэгжүүлээ.

2025 ОНД ГАРГАСАН НЭЭЛТТЭЙ ТАЙЛАНГУУД

Захиалагч/ өмчлөгч:
Дэлхийн Банк

Хэл:
Англи

Нэр:
Монгол Улсад уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох талаарх мэдлэг хандлага дадлын судалгааны үр дүн

Захиалагч/ өмчлөгч:
НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр

Хэл:
Монгол, Англи

Нэр:
Тэгш хүртээмжтэй эрчим хүчний шилжилтийн хүрээ

Захиалагч/ өмчлөгч:
НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр

Хэл:
Монгол, Англи

Нэр:
Монгол Улсын хиймэл оюун ухааны бэлэн байдлын үнэлгээ

Захиалагч/ өмчлөгч:
NCGE

Хэл:
Англи

Нэр:
"Жендэрийн эрх тэгш байдал ба уур амьсгалын өөрчлөлт" олон улсын хурлын товхимол

Захиалагч/ өмчлөгч:
Европын Холбоо

Хэл:
Монгол, Англи

Нэр:
Монгол Улс дахь хуурамч мэдээллийн зураглалын судалгаа

Захиалагч/ өмчлөгч:
Азийн Хөгжлийн Банк

Хэл:
Англи

Нэр:
Монгол Улс дахь эрэгтэйчүүдийн амьдралын туршлага, хүчирхийлэл үйлдэх байдлын судалгаа

БҮЛЭГ 3

Төслүүд

- IRIM-ийн санаачлан хэрэгжүүлсэн төслүүд
- Хэрэгжүүлсэн төслүүд
- Хэрэгжиж буй төслүүд



ЖИЛИЙН ТАЙЛАН 2023/2024

Хараат бус
Чанар

INDEPENDENT
RESEARCH
INSTITUTE OF
MONGOLIA

IRIM-ийн санаачлан хэрэгжүүлсэн төсөл



Төрийн байгууллагын мэдээллийн цахим ил тод байдлын индекс 2025

Төслийн танилцуулга

IRIM судалгааны хүрээлэн нь төрийн байгууллагын цахим ил тод байдлыг үнэлэх арга зүйг анх 2010–2011 онд боловсруулж, 2014 оноос хойш тогтмол хэмжиж ирсэн. Энэхүү арга зүй нь эхэндээ хуулийн хэрэгжилтийн мониторингд суурилж байсан бол 2019 онд шинэчлэгдэн эрх зүйн орчин болон байгууллагын чадамжийг хамарсан, олон улсын түвшинд ашиглах боломжтой “Цахим ил тод байдлын индекс” болон өргөжсөн. Шинэчилсэн арга зүйг Монгол болон Киргизстан Улсад амжилттай туршсан.

2026 онд индексийн арга зүйг дахин сайжруулж, үнэлгээний шалгуур үзүүлэлт, онооны логикийг нарийвчлахын зэрэгцээ олон улсын жишиг аргачлалтай нийцүүлсэн. Энэхүү шинэчлэл нь төрийн байгууллагын цахим ил тод байдлыг илүү системтэй, нотолгоонд суурилсан байдлаар үнэлэх үндсийг бэхжүүлэхэд чиглэж байна.

Төслийн арга зүй, аргачлал

Шинэчилсэн индекс нь дараах гурван үндсэн бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- Мэдээлэл авах эрхийн хэрэгжилт: Төрийн байгууллагын цахим хуудсаар дамжуулан мэдээлэл хүсэх боломж, нөхцөл, зохион байгуулалтыг үнэлэхийн зэрэгцээ иргэнээс туршилтын журмаар гаргасан мэдээлэл авах хүсэлтийн шийдвэрлэлтийн бодит практикийг үнэлнэ.
- Нээлттэй өгөгдлийн хүртээмж: Нээлттэй өгөгдлийн хүрээнд төрийн байгууллагын цахим хуудсанд байршуулсан мэдээллийн машин уншигдах формат, татаж авах боломж, мета мэдээллийн бүрдэл, шинэчлэлтийн байдал болон дэмжлэг үзүүлэх бүтэц, зохион байгуулалтыг үнэлсэн.
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт: Хуулиар нээлттэй байхаар заасан мэдээллийг төрийн байгууллага цахим орчинд бүрэн, тогтмол нийтэлж буй эсэхийг үнэлнэ.

Ялангуяа мэдээлэл авах эрхийн бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд зөвхөн цахим орчны бэлэн байдлыг үнэлэхээс гадна иргэнээс гаргасан мэдээлэл авах хүсэлтийн туршилтад тулгуурлан хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх бодит үйл явцыг үнэлэх аргачлалыг нэвтрүүлсэн нь энэхүү шинэчлэлийн онцлог юм.

Арга зүйг боловсруулахдаа нээлттэй өгөгдөл, мэдээллийн ил тод байдал болон нээлттэй засаглалын үнэлгээний чиглэлээр олон улсын түвшинд ашиглагддаг Open Data Barometer, Open Government Partnership-ийн үнэлгээний зарчим,

OECD-ийн нээлттэй засаглалын үзүүлэлтүүд, мөн төрийн мэдээллийн ил тод байдлын олон улсын сайн туршлагаудыг харгалзан үзсэн.

Эдгээр арга зүйн хүрээнд хэрэглэгддэг шалгуур, үнэлгээний логик, нотолгоонд суурилсан зарчмуудыг дотоодын нөхцөлд нийцүүлэн тусгаснаар индексийн бодитой байдал, найдвартай байдал, харьцуулах боломжийг сайжруулж, бодлогын түвшинд ашиглах ач холбогдлыг нэмэгдүүлсэн.

Шинэчилсэн арга зүйд үндэслэн гаргасан индексийн үр дүнг тайлангийн хэлбэрээр нэгтгэн танилцуулах бөгөөд тайлан нь төрийн байгууллагуудын цахим ил тод байдлын өнөөгийн түвшин, давуу болон сул тал, сайжруулах шаардлагатай чиглэлүүдийг тодорхойлсон бодлогын ач холбогдол бүхий баримт бичиг болно.

Тайлангийн хамт дараах бүтээгдэхүүнүүдийг олон нийтэд нээлттэй түгээхээр төлөвлөж байна. Үүнд:

- цахим ил тод байдлын индексийн үндсэн тайлан
- байгууллага тус бүрийн үнэлгээний нэгтгэсэн хүснэгт
- арга зүйн дэлгэрэнгүй тайлбар баримт бичиг
- үр дүнг харуулах интерактив dashboard

Төрийн байгууллагын цахим ил тод байдлын индексийн тайлан нийтлэгдсэний дараа та бүхэн www.irim.mn/web-monitoring хаягаар нэвтэрч дэлгэрэнгүй танилцах боломжтой.



2. Нээлттэй өгөгдлийн хүртээмж

ACCESSIBILITY



1. Мэдээлэл авах эрхийн хэрэгжилт

IMPLEMENTATION



3. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт

COMPLIANCE

RTI IMPLEMENTATION — OPEN DATA — LAW IMPLEMENTATION

— = ЦАХИМ ИЛ ТОД БАЙДАЛ —



IRIM-ийн санаачлан хэрэгжүүлсэн төсөл

ХАМТРАГЧ



Азийн нийгмийн сайн сайхан байдлын үндэсний хэмжээний хоёр дахь судалгаа: Монгол Улс

Төслийн танилцуулга

Манай байгууллага Олон улсын нийгмийн сайн сайхан байдлын судалгааны консорциумын гишүүн байгууллагын хувьд 2016 оноос хойш жил бүр “Монголын нийгмийн сайн сайхан байдлын судалгаа”-г санаачлан хэрэгжүүлж, мөн Консорциумын гишүүн байгууллагуудтай хамтран “Азийн нийгмийн сайн сайхан байдлын судалгаа”-г гүйцэтгэж ирсэн билээ.

Харин энэ удаа бид Азийн 8 (Монгол, Япон, БНСУ, Тайланд, Тайвань, Индонез, Филиппин, Вьетнам) улсыг хамран 2025-2026 оныг дуустал хэрэгжих, олон улсын хамтарсан хоёр дахь судалгаагаа гүйцэтгэхээр төлөвлөж байна. Уг судалгааны гол зорилго нь нийгмийн сайн сайхан байдал, нягтрал, итгэлцэл, хамтын ажиллагааны талаарх шинжлэх ухааны суурьтай бодит мэдээллийг бүрдүүлж, баримт нотолгоонд тулгуурласан шийдвэр гаргалтыг дэмжихэд хувь нэмрээ оруулахад оршино.




Судалгааны арга зүй

Судалгааны үр нөлөө, найдвартай байдал, чанарыг сайжруулах зорилгоор 2025 онд Консорциумын гишүүн байгууллагууд судалгааны арга зүйг хамтран сайжруулж, төсөл хэрэгжих 8 улсад туршсан. Үүний үр дүнд нийгмийн сайн сайхан байдлыг тодруулах тоон асуумжийг эцэслэж, 2026 онд Монгол Улсын 20–69 насны 1,200 иргэдийг хамарсан үндэсний хэмжээний судалгааг зохион байгуулахаар болов.

Түүврийг Улаанбаатар хот болон Баруун, Зүүн, Хангай, Төвийн бүсийн сонгогдсон аймгуудыг хамруулан олон шатлалт, санамсаргүй кластер түүврийн аргаар сонгон, мэдээлэл цуглуулалтыг 2026 оны 5 сард зохион байгуулахаар төлөвлөж байна.

Хүлээгдэж буй үр дүн

- “Монголчууд гэр бүл, найз нөхөд, хамт олон, нийгмийн ялгаатай бүлгүүд, цаашлаад танихгүй хүнд хэр итгэдэг вэ?”
- “Тэд төр, шашин, орон нутгийн байгууллага, УИХ, Засгийн газартаа хэр их итгэдэг вэ?”
- “Монголчууд бие биетэйгээ хэр хамтран ажиллаж, тусалж, нэгдэж, нийцэлтэй байдаг вэ?”
- “Тэд одоогийн амьдралдаа хэр сэтгэл халамжтай байдаг вэ?”
- “Тэдний амьдралын утга учир юу вэ?”
- “Монголчууд ирээдүйдээ хэр итгэлтэй байна вэ?” гэх мэт сонирхолтой атлаа хөгжлийн хамгийн чухал асуултуудын хариултыг энэхүү судалгааны үр дүнгээс харах боломжтой. Судалгааны тайланг 2027 оны эхээр олон нийтэд нээлттэй гаргахаар төлөвлөж байна.



Хэрэгжиж дууссан төсөл

ЗАХИАЛАГЧ, ХАМТРАГЧ, САНХҮҮЖҮҮЛЭГЧ



Тойрог эдийн засаг ба ногоон бизнесийн чиглэлд бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг чадавхжуулах зөвлөх үйлчилгээ

Төслийн танилцуулга

Дэлхий нийт байгалийн нөөцийг үр ашигтай, хаягдал багатай ашиглах, дахин хэрэглэгдэхүйц үйлдвэрлэлийг дэмжсэн тогтвортой эдийн засгийн загварт шилжиж байна. Гэвч КОВИД-19 цар тахал бүх түвшинд сөргөөр нөлөөлж, ялангуяа бичил, жижиг, дунд бизнесүүдэд хүндээр туссан нь тэдний сэргэлт, тогтвортой хөгжилд хүндрэл учруулсан. Энэ нөхцөлд уур амьсгалын өөрчлөлт болон цар тахлын дараах сэргэлтийг дэмжих зорилгоор Азийн хөгжлийн банк БНХАУ болон Монгол Улсад жендэрийн оролцоотой ногоон бизнесийг дэмжих бүс нутгийн техник туслалцааны төслийг санхүүжүүлсэн билээ.

IRIM судалгааны хүрээлэн нь “Тойрог эдийн засаг ба ногоон бизнесийн чиглэлд бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг чадавхжуулах зөвлөх үйлчилгээ”-г Монголын Тогтвортой Санхүүжилтийн холбоо, Хөгжлийн Шийдэл ТББ болон Германы зөвлөх үйлчилгээний “Адельфи” компанитай хамтран 2022-2025 онд 3.5 жилийн хугацаанд хэрэгжүүлээ.

Зөвлөх үйлчилгээ нь бичил, жижиг, дунд бизнес (БЖДБЭ)-ийн тойрог эдийн засаг (ТЭЗ), ногоон технологийн талаарх мэдлэг, чадавхыг бэхжүүлэх замаар жендэрийн тэгш байдлыг дэмжих үндсэн зорилготой. Тус зөвлөх үйлчилгээ нь эмэгтэй удирдлагатай БЖДБЭ-ийг КОВИД-19-ийн дараах хямралаас бизнесээ сэргээж, тогтвортой ногоон сэргэлтийг хийхэд нь туслах юм.

Төслийн үргэлжилсэн хугацаа

2022 оны 11 дүгээр сараас 2025 оны 5 дугаар сар хүртэл

Төслийн арга зүй, аргачлал

Төсөл нь 3 бүрэлдэхүүн хэсэгтэй хэрэгжсэн. Үүнд,

Аялал жуулчлалын салбарт ТЭЗ-ийн хандлагыг хэрэгжүүлэх боломж, саад бэрхшээлийг тодорхойлох цогц үнэлгээ

ТЭЗ-ийн чиглэлээр чадавх бэхжүүлэх хөтөлбөр

Үндэсний болон олон улсын хэлэлцүүлэг, арга хэмжээ

Хамрах хүрээ

Улаанбаатар, Хөвсгөл, Архангай аймагт байршилтай бичил, жижиг, дунд бизнес эрхлэгч нар

Төслийн зарим онцлох үр дүнгээс

Хэрэгцээ тодорхойлох судалгаа

Төсөл эхлэхэд 400 (72.5% нь Улаанбаатар хотод, 27.5% нь орон нутагт) бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдээс тойрог эдийн засгийн загварыг хэрэгжүүлэх хэрэгцээ тодорхойлох судалгаа авч, зөвлөх үйлчилгээний арга зүйг нарийвчилсан.

Санхүүгийн дэмжлэг

Аялал жуулчлалын салбарын хүнс, сав баглаа боодлын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй 15 эмэгтэй бизнес эрхлэгч тус бүр 9,000 ам.долларын санхүүжилт авч, эрчим хүчний


хэмнэлттэй тоног төхөөрөмж, сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмжүүд болон бизнесийн үйл ажиллагааны хамгийн их нөөц ашигладаг хэсгийг байгаль орчинд ээлтэй болгож загварчлах шийдлүүдийг хэрэгжүүлсэн.

Чадавх бэхжүүлэх арга хэмжээ

Нийт 350 эмэгтэй бизнес эрхлэгч 5 удаагийн танхимын болон онлайн сургалтад хамрагдсан. Сургалтад оролцогчдын тойрог эдийн засаг, нөөцийн хэмнэлт, хог хаягдлын менежмент, тэг хаягдал зэрэг сэдвүүдийн хүрээнд мэдлэг, хандлагын өөрчлөлтийг хэмжсэн. Сургалтын өмнөх, дараах үнэлгээний үр дүнгээс дор хураангуйлав.

Төслийн онцлох үр дүнг дор тоймлон хүргэж байна.

Оролцогчдын мэдлэгт гарсан эерэг өөрчлөлт



<p>Сургалтад хамрагдсгдын 90%+ нь сэтгэл ханамжтай гэж дүгнэсэн.</p>	<p>Бизнес эрхлэгчдийн тойрог эдийн засгийн талаарх мэдлэг 2 ДАХИН нэмэгдсэн.</p>	<p>16 Бизнес эрхлэгч тус бүр 9,000 ам.долларын тэтгэлэг аван инновацын шийдэл хэрэгжүүлсэн.</p>
<p>16 Бизнес эрхлэгчид стратегийн зөвлөх үйлчилгээг авч, бизнес загвараа шинэчилж, сайжруулсан.</p>	<p>Бизнес эрхлэгчдийн 67.3% нь нийгмийн хариуцлагын бодлогыг хэрэгжүүлэх шийдвэр гаргасан.</p>	<p>Жишиг бизнесүүдийн амжилтын түүх бий болсон.</p>
<p>Менторшип хөтөлбөрөөр дамжуулан урт хугацааны зөвлөх үйлчилгээ үзүүлж, дэмжлэг үзүүлсэн.</p>	<p>Бизнесүүд байгальд ээлтэй инновацын шийдэл боловсруулах чадвартай болсон.</p>	<p>Төсөл хэрэгжсэний дараа нөөцийн хэмнэлт, бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн талаар илүү ойлголттой болсон.</p>

Хэрэгжиж дууссан төсөл

ЗАХИАЛАГЧ



Монгол Улсад уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох талаарх мэдлэг, хандлага, дадлын судалгаа

Төслийн танилцуулга

Монгол Улсад уур амьсгалын өөрчлөлт (УАӨ) эрчимжиж, агаарын дундаж хэмийн өсөлт болон цаг агаарын ноцтой үзэгдлийн давтамж, эрч нэмэгдэж байгаа нь хөдөө орон нутгийн амьжиргаа, ялангуяа малчдын амьдралд ихээхэн нөлөө үзүүлж байна. Энэхүү судалгаа нь уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой иргэдийн мэдлэг, хандлага, дадал (КАР)-ын талаарх үндэсний төлөөлөл бүхий үнэлгээг гаргах зорилготой.

Энэхүү судалгаанд тоон болон чанарын судалгааны аргыг хослуулсан холимог арга зүйг ашигласан. Үүнд 1,426 оролцогчийг хамарсан тоон судалгаа, 24 ганцаарчилсан ярилцлага, 6 фокус бүлгийн хэлэлцүүлэг, мөн баримт бичгийн судалгаа хийж, 2025 оны 5 дугаар сард Улаанбаатар хотод судалгааны үр дүнг хэлэлцүүлэх уулзалт зохион байгуулсан.

Төслийн үргэлжилсэн хугацаа

2024 оны 9 дүгээр сараас 2025 оны 5 дугаар сар хүртэл


Төслийн зорилго

Иргэдийн УАӨ-ийн талаарх мэдлэг, бодит туршлага, түүний нөлөөллийн талаарх ойлголтыг тодорхойлох, ялангуяа хөдөө орон нутгийн иргэд болон малчдын хувьд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох болон түүнийг сааруулах бодлого, арга хэмжээг боловсруулахад шаардлагатай нотолгоонд суурилсан мэдээлэл бүрдүүлэхэд оршино.

Мэдлэг

Иргэдийн ихэнх нь агаарын хэмийн огцом хэлбэлзэл, цөлжилт зэрэг УАӨ-ийн шалтгаан, механизмын талаар хязгаарлагдмал мэдлэг, мэдээлэлтэй бөгөөд ихэвчлэн хувь хүний туршлага дээр тулгуурласан байна.

Иргэд УАӨ-ийн талаарх мэдлэгээ үнэлсэн байдал




Хандлага

Судалгаанд оролцогчдын дийлэнх нь УАӨ-ийг ноцтой аюул гэж үзэж, санхүүгийн дэмжлэг, гамшгийн нөлөөллийг даван туулахад чиглэсэн дэмжлэг зэрэг дасан зохицох арга хэмжээг дэмжих хандлагатай байна.

Дадал

Судалгаанд хамрагдсан олон малчин хувь хүний түвшинд УАӨ-ийн нөлөөг даван туулах арга хэмжээ авч байгаа боловч тогтвортой дадлыг хэрэгжүүлэхэд санхүүгийн боломж, технологи болон төрөөс үзүүлэх дэмжлэг хязгаарлагдмал хэвээр байна гэж үнэлжээ.

УАӨ-д дасан зохицох болон аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд орон нутгийн бусад иргэдтэй хамтран оролцох магадлал, судалгаанд оролцогчдын бүлгээр



Тогтвортой дадлуудыг хэрэгжүүлэхэд тулгарч буй сорилтууд



Хэрэгжиж дууссан төсөл

ЗАХИАЛАГЧ, ХАМТРАГЧ, САНХҮҮЖҮҮЛЭГЧ



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ



Government
of Japan



THE WORLD BANK
IBRD • IDA | WORLD BANK GROUP



IRIM
INDEPENDENT
RESEARCH
INSTITUTE OF
MONGOLIA

“Цахим хоршоо” төслийн суурь судалгаа

Төслийн танилцуулга

Монгол Улсын Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яамнаас Японы Засгийн Газрын Нийгмийн хөгжлийн сангийн буцалтгүй тусламж, Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр 2025–2027 оны хооронд хэрэгжүүлж буй “Цахим хоршоо” төслийн суурь судалгааны ажлыг IRIM судалгааны хүрээлэн хийж гүйцэтгэлээ. Энэхүү судалгааны зорилго нь “Цахим хоршоо” төслийн хэрэгжилтийн үндсэн нөхцөл, боломжийг тодорхойлох, төслийн цаашдын үйл ажиллагааг шинжилгээ, нотолгоонд суурилсан байдлаар төлөвлөхөд шаардлагатай суурь мэдээллийг бүрдүүлэхэд оршив. Судалгааны үр дүн нь төслийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг хэмжих анхны түвшнийг тогтоохоос гадна нэмүү өртгийн сүлжээний бодлого боловсруулах, дунд болон эцсийн шатны үнэлгээнд суурь болно.

Төслийн үргэлжилсэн хугацаа

Төсөл нь 2025 оны 6 дугаар сараас 2025 оны 9 дүгээр сар хүртэл.

Газарзүйн хамрах хүрээ

Цахим хоршоо төслийн зорилтот байршил болох Архангай аймгийн Батцэнгэл, Цэнхэр, Баянхонгор аймгийн Бөмбөгөр, Бууцагаан, Өвөрхангай аймгийн Арвайхээр, Баянгол, Ховд аймгийн Дарви, Мөст гэсэн 4 аймгийн 8 сумыг хамарсан.

Төслийн арга зүй

Төслийн үр дүнг хэмжих үндсэн шалгуур үзүүлэлтүүд нь малчин өрхийн үйлчилгээний хүртээмж, орлогын өсөлт, үйлдвэрлэлийн үр ашигт гарч буй өөрчлөлтийг хамарна.

Судалгаанд өрхийн асуумж, фокус бүлгийн хэлэлцүүлэг, түлхүүр мэдээлэгчийн ярилцлага зэрэг тоон болон чанарын судалгааны аргыг хослуулан ашиглаж, цугласан мэдээллийг албан ёсны статистик мэдээ, орон нутгийн бүртгэл мэдээлэлтэй уялдуулан тайлагнасан.

Төслийн зорилтот бүлэг нь 2,500 орчим малчин өрх (ойролцоогоор 8,500–9,000 хүн) бөгөөд суурь судалгаанд эмэгтэй болон ахмад өрхийн тэргүүнтэй, хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй, 200-аас доош малтай болон сумын төвөөс 30 км-ээс хол зайд оршин суудаг зэрэг эмзэг бүлгийн өрхүүдийг тусгайлан сонгож, нийт 141 өрхийг хамруулав.

Төслийн зарим онцлох үр дүнгээс

Энэхүү суурь судалгаагаар “Цахим хоршоо” төслийн хөгжлийн болон дунд шатны шалгуур үзүүлэлтүүдийн суурь түвшнийг тогтоож, доор хураангуйллаа.

Шалгуур үзүүлэлт 1. Цахим платформоор дамжуулан төрийн болон хувийн хэвшлийн үйлчилгээнд хамрагдаж буй төслийн үр шим хүртэгчид: Одоогийн байдлаар төслийн хүрээнд цахим платформ хараахан хөгжөөгүй тул суурь

түвшин 0-ээр тогтоогдсон. Гэвч судалгааны үр дүнгээс харахад, малчдын дийлэнх нь цахим үйлчилгээг ашиглах өндөр хэрэгцээ, сонирхолтой байгаа боловч дижитал мэдлэг, ур чадвар дутмаг, интернэт холболтын хүртээмж хангалтгүй байгаа нь бодит хэрэглээг хязгаарлаж байна.

Шалгуур үзүүлэлт 2. Зохистой дадал хэрэгжүүлсэн малчин өрхийн ноос, ноолуурын борлуулалтын орлогын нэг хүнд ногдох инфляцаас цэвэршүүлсэн үнийн өсөлт: Суурь түвшин ийнхүү тогтоогдсон ч зохистой дадлыг хэрэгжүүлдэг өрхүүд нийт малчдын 5.9%-д хүрэхгүй байгаа нь орлогын өсөлт, нэмэлт үнийн урамшууллын боломжийг хязгаарлаж байна. Зорилтот төслийн санхүүжилт болон бодит дэмжлэг одоогоор бүртгэгдээгүй нь эхний шатанд сургалт, чадавхжуулах арга хэмжээг эрчимжүүлэх зайлшгүй шаардлагатайг илтгэнэ. Энэхүү үзүүлэлт нь цаашид төслийн үр нөлөөг хэмжих гол шалгуурын нэг байх тул малчид малын гаралтай түүхий эдийг бэлтгэж, зах зээлд нийлүүлэх үйл явцдаа илүү хариуцлагатай хандаж, зохистой дадлыг өргөнөөр нэвтрүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Шалгуур үзүүлэлт 3. Зохистой дадлыг хэрэгжүүлсэн малчин өрхийн нэг малаас гарах ноос, ноолуурын гарцын өсөлт: Чанарын стандарт мөрдөхгүй байх, зөвхөн энгийн цэвэрлэгээ хийх, хадгалалт, ангиллын дэд бүтэц хангалтгүй байх зэрэг хүчин зүйлс нь тоо хэмжээ болон чанарын өсөлтөд саад болж байна. Үүнээс гадна, түүхий эдийн нийлүүлэлтийн сүлжээн дэх ченжийн давамгайлал, бэлчээрийн доройтол, уур амьсгалын өөрчлөлт зэрэг гадаад хүчин зүйлс эрсдэлийг нэмэгдүүлж байгаа нь тогтвортой өсөлтийг хязгаарлаж байна.

Чанарын мэдээлэл
цуглуулалтын явц,
Ховд аймаг



Тоон мэдээлэл
цуглуулалтын явц,
Ховд аймаг



Чанарын мэдээлэл
цуглуулалтын явц,
Архангай аймаг



Хэрэгжиж дууссан төсөл

ЗАХИАЛАГЧ, ХАМТРАГЧ, САНХҮҮЖҮҮЛЭГЧ



Dalberg

“Нийтийн цахим дэд бүтцийн нэвтрүүлэлт дэх хүртээмжийг хэмжих нь” судалгааны мэдээлэл цуглуулалт

Төслийн танилцуулга

Дэлхийн өнцөг булан бүрд олон улс орнууд цахим үнэмлэх, цахим төлбөр тооцоо, өгөгдөл солилцоо зэрэг Нийтийн цахим дэд бүтэц (НЦДБ)-ийг нэвтрүүлж, төрийн болон хувийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулж байна. Зөв хэрэгжсэн НЦДБ нь иргэдийн санхүүгийн оролцоо, нийгмийн хамгаалал, эдийн засгийн боломжийг нэмэгдүүлдэг ч аль бүлгүүд илүү хамрагдаж, аль нь илүү орхигдож байгааг бодитоор хэмжих тогтолцоо хангалтгүй хэвээр байна. Иймээс Co-Develop болон Dalberg байгууллагууд хамтран “Inclusivity Pulse for DPI” төслийг санаачлан хэрэгжүүлж байна. Ингэхдээ НЦДБ-ийн хүртээмжийг стандартчилсан үзүүлэлт, асуулгад суурилсан тоон судалгаагаар хэмжих аргачлал боловсруулсан бөгөөд хүртээмжийг (1) суурь НЦДБ-д нэвтрэх боломж болон (2) НЦДБ-д суурилсан үйлчилгээг ашиглах боломж гэсэн хоёр түвшинд үнэлж, илүү бодит зураглал гаргахыг зорьж байна.

Зорилго

Энэхүү судалгааны зорилго нь НЦДБ-ийг бүх нийтэд хүртээмжтэй болгоход тулгарч буй саад бэрхшээлийг тодорхойлж, бодлого боловсруулагчдыг нотолгоонд суурилсан мэдээллээр хангах, улмаар хэнийг ч орхигдуулахгүй байх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино. Одоогоор төсөл туршилтын шатандаа хэрэгжиж байгаа бөгөөд Монгол болон Малави улсуудад судалгаа хийгдэж байна. Монгол Улс дахь мэдээлэл цуглуулах ажлыг IRIM судалгааны хүрээлэн гүйцэтгэсэн. Судалгаа нь Монгол Улсын голлох НЦДБ-ийн систем, төрийн үйлчилгээний нэгдсэн цахим платформ болох И-Монголыг иргэд хэрхэн ашиглаж буйг тодорхойлж, цахим орчноос орхигдож болзошгүй бүлгүүдийн туршлага, тулгарч буй хүндрэл бэрхшээлийг илрүүлэхэд чиглэсэн. Энэхүү үнэлгээний үр дүнд тулгуурлан төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад чиглэсэн бодлогын зөвлөмж, дэмжлэг боловсруулахыг зорьж байна.

Арга зүй

Төслийн ерөнхий арга зүй, хэрэглэгдэхүүнийг захиалагчбайгууллагаболовсруулсанбаингэхдээ НЦДБ-д зориулсан стандартчилсан судалгааны хүрээг хоёрдогч судалгааны үр дүн, дижитал эрх ба хүртээмжийн чиглэлээрх мэргэжилтнүүд, иргэний нийгмийн байгууллагууд, мөн И-Монгол Академиас ирүүлсэн санал, мэдээлэлд тулгуурлан И-Монгол платформын онцлогт нийцүүлэн сайжруулсан. Судалгааны дизайн болон асуулгын эхний хувилбарыг Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс болон

Техникийн зөвлөх хорооны гишүүд хянан санал өгч, баталгаажуулсан.

Судалгааны мэдээлэл цуглуулалтын хүрээнд 1,000 гаруй иргэнийг тоон судалгаанд хамруулсан. Түүвэрт бага орлоготой, хөдөө орон нутгийн, малчин, ахмад настай, хөгжлийн бэрхшээлтэй зэрэг орхигдож болзошгүй бүлгүүдийн төлөөллийг зориудаар хамруулсан.

Төслийн үргэлжилсэн хугацаа

2025 оны 5 дугаар сараас 2025 оны 7 дугаар сар хүртэл

Газар зүйн хамрах хүрээ

Улаанбаатар хотын 6 дүүрэг, Сэлэнгэ аймаг (Сүхбаатар, Баянгол, Мандал сумд), Хөвсгөл аймаг (Мөрөн, Арбулаг, Алаг-Эрдэнэ, Түнэл сумд) болон Говь-Алтай аймаг (Цогт, Бигэр сумд)

Судалгааны зарим онцлох үр дүнгээс

Залуучууд, хот, аймгийн төвийн иргэд болон өндөр орлоготой хүмүүсийн дунд бүртгэл хамгийн өндөр; харин ахмад настай, хөдөө орон нутагт амьдардаг, орлого багатай, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон малчдын дунд бүртгэл хамгийн бага байна.

Бүртгүүлээгүй оролцогчдын хувьд бүртгэл хийхэд тулгардаг хамгийн гол саад бэрхшээл нь мэдлэг ойлголт болон цахим мэдлэг, ур чадварын хязгаарлагдмал байдал, технологийн асуудал гэж дурджээ.

79% & 60%

Судалгаанд оролцсон хот/аймгийн төвийн иргэдийн 79%, хөдөө орон нутгийн иргэдийн 60% нь И-Монгол платформд бүртгэлтэй

88%

И-Монгол платформд бүртгэлтэй хэрэглэгчдийн 88% нь сүүлийн 12 сард дор хаяж 1 удаа үйлчилгээ авсан

85%

И-Монгол платформын идэвхтэй хэрэглэгчдийн 85% нь гар утасны аппликейшнээр дамжуулан хэн нэгний тусламжгүйгээр өөрсдөө үйлчилгээ авсан

96%

И-Монгол платформд бүртгэлтэй хэрэглэгчдийн 96% нь платформын дор хаяж 1 удаа үйлчилгээ авсан

70%

И-Монгол платформын идэвхтэй хэрэглэгчдийн 70% нь платформыг хэрэглэх явцад ямар нэгэн хүндрэлтэй тулгардаггүй гэж хариулсан

93%

Судалгаанд оролцсон И-Монгол платформд бүртгэлгүй хэрэглэгчдийн 93% нь төрийн байгууллагад биечлэн очиж үйлчилгээ авч байна

Хэрэгжиж дууссан төсөл

ЗАХИАЛАГЧ, ХАМТРАГЧ, САНХҮҮЖҮҮЛЭГЧ



COLLÈGES & INSTITUTS CANADA

COLLEGES & INSTITUTES CANADA



ADVISEM

“SkillShift” төслийн суурь судалгаа

Төслийн үндэслэл

“SkillShift” Mongolia нь Канадын Гадаад Харилцааны Яамны санхүүжилтээр CИCan болон Монгол Улсын Боловсролын Яам (БЯ) хамтран хэрэгжүүлэх таван жилийн хугацаатай хөтөлбөр юм. Энэхүү хөтөлбөр нь Монгол Улсын залуучуудыг, тэр дундаа эмэгтэйчүүд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг Техник мэргэжлийн боловсрол, сургалт (ТМБС)-ын тогтолцоогоор дамжуулан хөдөлмөрийн зах зээлд нийцсэн үр чадвараар хангаж, эдийн засаг, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулахад нь дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

Үргэлжилсэн хугацаа

2025 оны 9 дүгээр сараас 2026 оны 2 дугаар сар хүртэл.



Төслийн танилцуулга

Төсөл дараах үндсэн дөрвөн бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.

Шинээр Ажил мэргэжлийн стандарт (АМС) боловсруулах хөтөлбөр

ТМБС-ын байгууллагын удирдлагыг чадавхжуулах хөтөлбөр

ТМБС-ын байгууллагын жендэрийн эрх тэгш байдлыг хангах, тэгш хамруулах бодлого

Багш нарыг чадавхжуулах үндэсний сургалтын хөтөлбөр

Суурь судалгааны түүвэр

698 Тоон судалгаа

28 Ганцаарчилсан ярилцлага

6 Фокус бүлгийн ярилцлага

Хүлээгдэж буй үр дүн

IRIM судалгааны хүрээлэнгийн зохион байгуулан цуглуулсан дата мэдээллийг ашиглан CИCan болон AdviseM байгууллагууд “SkillShift Mongolia” төслийн суурь судалгааны тайланг боловсруулж, Монгол дахь төслийн нэгж болон Боловсролын яаманд хүлээлгэн өгөх ба уг тайлан төслийн зорилго, зорилт, үйл ажиллагааг төлөвлөх, хянах, дунд шатны болон эцсийн шатны үнэлгээ хийхэд ашиглагдах юм.

Төслийн арга зүй

IRIM нь сонгогдсон аймгийн Политехник коллежуудаас суурь судалгааны мэдээлэл цуглуулж, “SkillShift” төсөл хэрэгжиж эхлэх үеийн нөхцөл байдлыг тодорхойлохоор 2025 оны 9 дүгээр сараас 10 дугаар сарыг дуустал Канадын зөвлөх үйлчилгээний баг AdviseM Services Inc байгууллагатай хамтран ажиллаа.



Хэрэгжиж дууссан төсөл

ЗАХИАЛАГЧ, ХАМТРАГЧ, САНХҮҮЖҮҮЛЭГЧ

aan
associates

unicef

НҮБ-ын Хүүхдийн Сангийн WASH хөтөлбөрийн эцсийн үнэлгээний мэдээлэл цуглуулах төсөл

Төслийн үндэслэл

НҮБ-ын Хүүхдийн Сан (UNICEF) нь 2017–2022 онд Завхан, Говь-Алтай, Баянхонгор аймгуудад аюулгүй, тэгш хүртээмжтэй ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуй (WASH)-н хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Хөтөлбөрийн хүрээнд сургууль, цэцэрлэг, дотуур байр, эрүүл мэндийн байгууллага болон олон нийтэд чиглэсэн ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн цогц арга хэмжээ хэрэгжсэн билээ. Уг хөтөлбөр зорилгодоо хүрсэн эсэхийг үнэлэх, орон нутагт бий болсон өөрчлөлт, үр нөлөөг тодорхойлох, цаашид үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхэд шаардлагатай сургамж, сайн туршлагыг илрүүлэх зорилгоор хөндлөнгийн эцсийн үнэлгээг Исламын Бүгд Найрамдах Пакистан Улсад төвтэй AAN Associates байгууллага удирдан гүйцэтгэж, үндэсний зөвлөх багаар IRIM судалгааны хүрээлэн хамтран ажиллаа.

Үргэлжилсэн хугацаа

2025 оны 11 дүгээр сараас 2026 оны 1 дүгээр сарыг дуустал.

Арга зүй

Төслийн мэдээлэл цуглуулалт нь дараах хосолсон үнэлгээний загварт үндэслэсэн болно. Үүнд:

- **Үр дүн цуглуулах (Outcome Harvesting)**

WASH үйлчилгээ, талуудын зан төлөв, салбарын бодлого болон системд гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох.

- **Онолд суурилсан хандлага**

Хөтөлбөрийн Өөрчлөлтийн онол (Theory of Change) болон гол шалтгаан-үр дагаврын холбоосуудыг шалгаж, нягтлах.

- **Нөлөөллийг бус, хувь нэмрийг үнэлэх:**

Олон оролцогч бүхий системийн хүрээнд UNICEF-ийн оруулсан бодитой хувь нэмрийг логик үндэслэлтэйгээр үнэлэх.

- **Урвуу чиглэлтэй шинжилгээ:** Хөтөлбөр хэрэгжсэн хугацаанд гарсан үр дүнг ухраан шинжилж, өмнөх болон одоогийн хөтөлбөрийн үе шатанд гарсан ололт амжилт, сургамжийг тодорхойлох.

- **Ашиглалт төвтэй, оролцоонд суурилсан, уян хатан хандлага:** Үнэлгээг үнэлгээний лавлах бүлэг буюу ERG болон оролцогч талуудтай хамтран, тэдний саналыг ашиглах.

IRIM нь сонгогдсон аймгийн Политехник коллежуудаас суурь судалгааны мэдээлэл цуглуулж, "SkillShift" төсөл хэрэгжиж эхлэх үеийн нөхцөл байдлыг тодорхойлохоор 2025 оны 9 дүгээр сараас 10 дугаар сарыг дуустал Канадын зөвлөх үйлчилгээний баг Advisem Services Inc байгууллагатай хамтран ажиллаа.

Хамрах хүрээ

Ажиглалт (Байгууллага)

20	10	Боловсролын
	10	Эрүүл мэндийн

Кейс судалгаа

5	2	Баянхонгор
	3	Говь-Алтай

Бүлгийн ярилцлага

8	4	Баянхонгор
	4	Говь-Алтай

Ганцаарчилсан ярилцлага

18	12	Улаанбаатар
	2	Баянхонгор
	4	Говь-Алтай



Хэрэгжиж дууссан төсөл

ЗАХИАЛАГЧ, ХАМТРАГЧ, САНХҮҮЖҮҮЛЭГЧ



“Тэгш хүртээмжтэй эрчим хүчний шилжилтийн хүрээ”-г боловсруулах зөвлөх үйлчилгээ

Төслийн танилцуулга

Монгол Улсын эрчим хүчний салбар нүүрснээс өндөр хамааралтай хэвээр байгаа нь уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хүлээсэн үүрэг амлалт, агаарын бохирдлыг бууруулах зорилт, эрчим хүчний аюулгүй байдал, бүс нутгийн хөгжлийн тэгш бус байдал зэрэг олон талт сорилтыг дагуулж байна. Эрчим хүчний шилжилт нь зөвхөн технологийн шинэчлэл бус, хөдөлмөр эрхлэлт, орлогын тогтвортой байдал, нийгмийн хамгаалал, жендэрийн тэгш байдал, эмзэг бүлгийн оролцоо зэрэг нийгэм-эдийн засгийн өргөн хүрээний нөлөөлөл бүхий цогц өөрчлөлт юм. Иймээс шилжилтийг нийгмийн шударга ёс, хүртээмжийн зарчимд тулгуурлан бодлого, институцийн бэлэн байдал, хамгааллын механизмтай уялдуулан хэрэгжүүлэх шаардлага бий болсон.

Энэ хүрээнд IRIM судалгааны хүрээлэн Монгол Улсын эрчим хүчний шилжилтийг нийгмийн шударга ёс, хүртээмжийн зарчимд тулгуурлан стратегийн түвшинд чиглүүлэх “Тэгш хүртээмжтэй эрчим хүчний шилжилтийн хүрээ” болон дагалдах үнэлгээний тайланг боловсруулсан. Судалгааны хүрээнд бодлого, эрх зүйн орчин, институцийн зохион байгуулалт, салбар хоорондын уялдаа, нийгэм-эдийн засгийн нөлөөллийг шинжилсэн бөгөөд 6 улсын туршлагыг харьцуулан Монголын нөхцөлд нийцүүлэх боломжийг тодорхойлсон. Төсөл нь 2025–2026 онд үндэсний түвшинд хэрэгжиж, эрчим хүчний шилжилтийг нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, жендэрийн тэгш байдалтай уялдуулах бодлогын нэгдсэн суурь баримт бичгийг бүрдүүлсэн юм.

Эх сурвалж: Монгол Улсын Засгийн Газар



Үр дүн, дүгнэлт

“Тэгш хүртээмжтэй эрчим хүчний шилжилтийн хүрээ”-нд эрчим хүчний системийг малтмал түлшнээс цэвэр эрчим хүч рүү шилжүүлэхдээ нийгмийн тэгш байдал, оролцоо, хамгааллыг хангах цогц хандлагыг баримтлах тухай онцолсон. Энэхүү баримт бичгээр нь тэгш байдлыг хангах гурван тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон.



Нийгмийн оролцоо ба хамгааллын арга хэмжээ

Эрчим хүчний дэмжлэг, татаасны тогтолцоо нь давхардсан, зорилтот бус, байгууллага хоорондын зохицуулалт сул хэвээр байгаа тул хамгийн эмзэг өрхүүд орхигдох, харин чинээлэг өрхүүд илүү ашиг хүртэх хандлага ажиглагдаж байна. Одоогийн түр шинжтэй дэмжлэгүүд нь цэвэр технологи, урт хугацааны шилжилтийн зорилготой бүрэн нийцэхгүй, төсөвт дарамт учруулж байна. Тиймээс бүх нийтийн татаасыг орлогод суурилсан зорилтот дэмжлэг болгон шинэчилж, “нэг өрх–нэг бүртгэл” зарчмаар мэдээллийн нэгдсэн систем бүрдүүлэх; алдагдлын татаасыг гүйцэтгэл, үр ашигтай уялдуулах; хэмнэсэн нөөцийг “Хэмнэлт ба шилжилтийн сан”-д төвлөрүүлж дулаалга, ухаалаг тоолуур, сэргээгдэх шийдэл зэрэг урт хугацааны цэвэр технологид чиглүүлэх хэрэгтэй.



Ажиллах хүчний шилжилт, ур чадварын хөгжил

Эрчим хүчний шилжилтээс үүдэх хөдөлмөрийн бүтцийн өөрчлөлтийг удирдах нэгдсэн бодлого, зохицуулалт дутмаг, сургалтын тогтолцоо шинэ технологийн эрэлттэй нийцэхгүй байна. Нүүрсний салбарын ажилчид, нүүрснээс

хамааралтай бүс нутгийн иргэдийн орлогын эрсдэл нэмэгдэх, ур чадварын зөрүү үүсэх магадлалтай. “Ажиллах хүчний шилжилтийн үндэсний стратеги” боловсруулж, салбар хоорондын хөдөлмөрийн урсгалын зураглал гаргах; “Ногоон ур чадварын үндэсний хөтөлбөр”-өөр дамжуулан дахин сургалт, лаборатори, багшийн чадавхыг бэхжүүлэх; нүүрсний ажилчдад орлогын түр дэмжлэг, дахин сургалт, шилжилтийн төв, сайн дурын эрт тэтгэвэр хэрэгжүүлэх; залуус, эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх хосолмол сургалт–ажил эрхлэлтийн тогтолцоо нэвтрүүлэх шаардлагатай.



Эдийн засгийн өсөлт, ЖДҮ-ийн дэмжлэг ба бүс нутгийн төрөлжилт

Нүүрснээс хамааралтай бүс нутгийн эдийн засаг нэг тулгуурт төвлөрсөн, ЖДҮ-үүд эрчим хүчний үнийн өсөлт, санхүүжилтийн хязгаарлалтаас шалтгаалан дарамтад орж, шилжилтэд идэвхтэй оролцох чадавх сул байна. Бүсэд суурилсан шилжилтийн мастер төлөвлөгөө, ногоон кластер, “шилжилтийн парк” байгуулж эдийн засгийг төрөлжүүлэх; ЖДҮ-д “Тогтворжуулах–Хэмнэх–Шилжих” үе шаттай бодлого, “хэмнэлтээрээ төлөх” санхүүжилт, холимог санхүүжилт ба батлан даалтын механизм нэвтрүүлэх; бичил-гэрээлэгчийн стандарт, нээлттэй дата, “нэг цонхны” зохицуулалтаар ЖДҮ-ийг шилжилтийн шийдэл нийлүүлэгч болгон чадавхжуулах шаардлагатай.



Тэгш хүртээмжтэй эрчим хүчний шилжилтийн нийгэм-эдийн засгийн үр нөлөө

Эрчим хүчний шилжилтийн 3 хувилбарыг харьцуулж нийгэм-эдийн засгийн нөлөөг үнэлсэн ба энэ нь өрхийн төлбөрийн чадвар болон хөдөлмөр эрхлэлтийн өөрчлөлтөөр тодорхойлогдох юм.

Хөдөлмөрийн зах зээлд гарах нөлөө

Хөдөлмөрийн зах зээлд нүүрсний салбарт 1,648 ажлын байр буурах боловч сэргээгдэх болон цэвэр технологийн салбарт 1,067 шинэ ажлын байр бий болохоор байна. Иймээс шилжилт нь эрсдэл ба боломжийг хамтад нь агуулж байгаа бөгөөд дахин сургалт, орлогын дэмжлэг, орон нутгийн ажлын байр бий болгох бодлогоор идэвхтэй удирдах шаардлагатай. Дүгнэж хэлбэл, ялгарлын бууралтыг нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн шилжилттэй уялдуулсан цогц, тэгш хүртээмжтэй бодлого хэрэгжүүлсэн тохиолдолд шилжилт нийгэм-эдийн засгийн тогтвортой байдлыг хангах боломжтой.

Эрчим хүчний шилжилтээс гэр хорооллын ядуу өрхөд ирэх эрчим хүчний төлбөрийн дарамт

Хувилбар	Дулаацуулгын технологи	Тайлбар	Сарын орлогод эзлэх хувь, %					
			2010	2015	2020	2025	2030	2035
Суурь	Шахмал түлш, хагас кокс, цахилгаан халаагуур	Богино хугацаанд зардал бага мэт боловч хуучин нүүрсний дэд бүтцийн өсөх зардал, түлшний үнийн савлагаанаас хамааралтай хэвээр үлдэнэ.	12.4%	12.4%	12.4%	16.2%	14.5%	12.9%
Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (ҮТХН) 3.0	Шахмал түлш, хагас кокс, цахилгаан халаагуур, шингэрүүлсэн нефтийн хийн түлш	Ялгарлыг бууруулах зорилготой ч үйлдвэрлэлийн өртөг хамгийн өндөр тул ялангуяа бага орлоготой өрхүүдэд хэт их санхүүгийн дарамт үүсгэх эрсдэлтэй.	12.4%	12.4%	12.4%	30.7%	43.0%	47.8%
Тогтвортой хөгжлийн зорилт (ТХЗ)-7	Нарны халаагуур, дулааны насос	Анхны хөрөнгө оруулалт өндөр боловч сэргээгдэх эх үүсвэрт тулгуурласан "тэг түлшний зардал"-ын бүтэц нь урт хугацаанд илүү тогтвортой, өрсөлдөхүйц өртөг, түлшний эрсдэлийг бууруулна. Иймээс өртөг-үр ашгийн тэнцвэр, нийгмийн хамгааллын бодлоготой уялдсан цогц шинэчлэл бүхий хувилбар нь стратегийн хувьд илүү оновчтой шийдэл болно.	12.4%	12.4%	12.4%	15.0%	22.8%	26.8%

Хэрэгжиж дууссан төсөл

ЗАХИАЛАГЧ



Залуучуудын сургуулиас хөдөлмөрийн зах зээл рүү шилжих шилжилтийн судалгаа

Төслийн танилцуулга

2025 оны байдлаар Монгол Улсад 15–29 насны ойролцоогоор 748,000 залуучууд байгаа нь нийт хүн амын 21 орчим хувийг эзэлж байна. Залуус сургуулиа төгсөөд хөдөлмөрийн зах зээл рүү шилжиж, ажлын байртай болоход ялгаатай олон замыг туулж, тодорхой бэрхшээлтэй тулгардаг болохыг судалгаануудад дурдсан байдаг. Харин энэ удаа IRIM судалгааны хүрээлэн залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдал, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох зорилгоор АХБ-ны захиалгаар "Залуучуудын сургуулиас хөдөлмөрийн зах зээл рүү шилжих шилжилтийн судалгаа"-ны мэдээлэл цуглуулалтын ажлыг хийж гүйцэтгэлээ.

Судалгааны арга зүй

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдал, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох зорилгоор 800 өрхийн 18-49 буюу хөдөлмөрийн насны гишүүн бүрээс асуумжийн аргаар тоон мэдээлэл цуглууллаа.

Газарзүйн хамрах хүрээ

Улаанбаатар болон Дархан хот

Үргэлжилсэн хугацаа

Мэдээлэл цуглуулалт 2025 оны 2 сараас 2025 оны 6 сарыг дуустал үргэлжилсэн.

Хүлээгдэж буй үр дүн

Энэхүү судалгааны мэдээлэл нь АХБ-наас Монгол Улсын Засгийн газартай хамтран хэрэгжүүлж буй "Төслийн инновац, туршилт, түгээн дэлгэрүүлэхэд зориулсан мэдлэгийг нийтийн баялаг болгон бэхжүүлэх" бүс нутгийн техникийн туслалцааны төслийн хүрээнд залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, хөтөлбөрийг боловсронгуй болгоход шаардлагатай суурь мэдээлэл болон ашиглагдах юм.

Хэрэгжиж буй төсөл

ЗАХИАЛАГЧ, ХАМТРАГЧ, САНХҮҮЖҮҮЛЭГЧ



“Монгол Улс дахь жендэр-смарт бизнесүүдийг дэмжих нь” туршилтын төсөл



Төслийн танилцуулга

2025 оны 4 дүгээр сард IRIM судалгааны хүрээлэн ЖАЙКА-ийн захиалгаар “Жендэрт суурилсан хүчирхийллийн нөхцөл байдлын судалгаа”-г гүйцэтгэж, хүчирхийллийн хохирогчдод богино хугацааны хамгаалалт, халамж давамгайлж, харин урт хугацааны эдийн засгийн бие даасан байдлыг дэмжих, нөхөн сэргээх үйлчилгээ дутмаг байгааг тогтоосон.

Уг үр дүн болон ЖАЙКА-гийн “Gender Equality and Women’s Empowerment” глобал стратегийн хүрээнд жендэрт суурилсан хүчирхийлэл (ЖСХ)-д өртөх эрсдэлтэй эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн бие даасан байдлыг бэхжүүлэх зорилгоор энэхүү “Монгол Улс дахь жендэр-смарт бизнесүүдийг дэмжих нь” туршилтын төслийг санаачлан хэрэгжүүлсэн.

Төслийг УБ хотын Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн өрхийн болон бичил, жижиг, дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг зорилтот бүлгээр сонгон, жендэр-смарт бизнесийн үзэл баримтлалд тулгуурлан хэрэгжүүлэв.

Төсөл нь бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд тулгамдаж буй асуудал, дэмжлэгийн орчны нөхцөл байдлыг цогцоор нь тодруулсны үндсэн дээр тус хэрэгцээнд нийцүүлсэн чадавх бэхжүүлэх, бизнес хөгжлийг дэмжих цогц хөтөлбөрийн дизайныг туршиж, ЖАЙКА-с цаашид урт хугацаанд хэрэгжүүлэх стратегийн чиглэл, арга зүйг нарийвчлан тодорхойлох зорилготой байв.

Үргэлжилсэн хугацаа

2025 оны 9 дүгээр сараас 2026 оны 2 дугаар сар хүртэл.

Төслийн дизайн, арга зүй

Энэ хүрээнд төсөл нь судалгаа–сургалт–бизнес санааны уралдаан гэсэн уялдаа бүхий дараах гурван бүрэлдэхүүнтэй хэрэгжив.

Үе шат	Үйл ажиллагаа
1. Судалгаа	<ul style="list-style-type: none"> Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн нийт 245 бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг хамруулав. Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн нөхцөл байдал, тулгарч буй бэрхшээлүүдийг тодруулав Төрөөс бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд чиглэсэн бодлого, хөтөлбөрүүдийг шинжлэх ТББ, ОУБ, хувийн хэвшлийн байгууллагуудын зүгээс бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд чиглэсэн бодлого, төсөл хөтөлбөрүүдийг шинжлэх
2. Сургалт	<p>Нийт 30+ бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд: (1) Бизнес хөгжил, (2) Санхүүгийн менежмент, (3) Жендэрийн эрх тэгш байдлын сургалтууд</p> <p>БЗД-ийн ЖДУ дэмжих төвд: (1) Жендэрийн мэдрэмжтэй менторинг, (2) Зах зээлийн судалгааны арга зүйн сургалтууд</p> <p>Банк, санхүүгийн байгууллагуудад: Санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний үр нөлөөг жендэрийн мэдрэмжтэй үнэлэх арга зүйн сургалт</p>
3. Тэмцээн	<ul style="list-style-type: none"> Үйл ажиллагаа эрхэлж буй бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн дунд Гарааны бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн дунд Жендэр-Смарт бизнес санааны уралдааныг зохион байгуулж ангилал тус бүрд эхний 3 байрыг шалгаруулж грант олгов.

Зарим онцлох үр дүнгээс

Судалгаагаар гарч ирсэн эмэгтэй бизнес эрхлэгчдийн нөхцөл байдалтай холбоотой онцлох үр дүнгүүдээс дурдвал:

Эдгээр үр дүн болон төслийн туршлага сургажид үндэслэн цаашид бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих үйл ажиллагаанд өгч буй зөвлөмжүүд:

- Цогц хандлага:** Эмэгтэйчүүдийг дэмжих хөтөлбөр нь эмэгтэйчүүдийг бага бүтээмжтэй салбараас өндөр орлоготой, өсөлтийн чиг баримжаатай салбаруудад холбож, ур чадвар, зах зээлийн интеграцчилал, асаргаа дэмжлэгийг хослуулсан цогц арга хэмжээгээр тогтвортой, бие даасан орлогыг бэхжүүлэх;

- Шилжилт:** Төрийн бодлого нь эмэгтэй бизнес эрхлэгчдийн “амь зогоох” санхүүжилтийн хэв маягийг халж, эрсдэл хуваалцах механизмтай, өсөлтийг дэмжсэн тогтвортой санхүүгийн хэрэгслүүдийг хөгжүүлэх;
- Баталгаа:** Зээлийн баталгаа, эхний алдагдлыг хариуцах болон хамтарсан санхүүжилтийн механизм нь санхүүгийн байгууллагуудад урт хугацаатай, уян хатан бүтээгдэхүүн санал болгох боломж бүрдүүлж, эмэгтэйчүүдийн хөрөнгийн суурь ба өсөлтийг дэмжих;
- Өсөлтийг дэмжсэн санхүүгийн бодлого:** Бизнесийг албажуулах, хөрөнгийн өмчлөл нэмэгдүүлэх үйл явцыг үе шаттай, хөнгөвчилсөн хэлбэрээр дэмжих нь эмэгтэйчүүдийн зээлжих чадвар, санхүүгийн тэсвэртэй байдал, урт хугацааны эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх;
- Жендэрт суурилсан хүчирхийлэл:** Эмэгтэйчүүдийн бизнесийг дэмжих бүх хөтөлбөр нь жендэрт суурилсан хүчирхийллийн эрсдэлийг тооцсон, өрхийн харилцаанд мэдрэмжтэй, хамгаалалт ба нийгмийн хандлагын өөрчлөлтийг хослуулсан байдлаар хэрэгжүүлэх.

Эцэст нь дүгнэвэл, эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг зөвхөн орлогын түвшнээр хязгаарлан хэмжих бус, бизнес дэх шийдвэр гаргах оролцоо, эрх мэдлийн тэнцвэр, асаргааны ачаалал, мөн жендэрт суурилсан хүчирхийллийн туршлагатай уялдуулан цогц, харилцан хамааралтай байдлаар үнэлэх нь эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг дэмжихэд илүү үр нөлөөтэй арга хандлага байх болно.

1 АСАРГААНЫ ҮҮРЭГ

Эмэгтэйчүүд асаргаа, халамжийн давхар ачааллыг үүрч, өрхийн орлого бүрдүүлэх үүрэгтэй зэрэгцэн ажиллаж байгаа нь тэднийг байнгын эдийн засгийн дарамтад оруулж, санхүүгийн эрсдэл даах чадварыг сулруулж байна.

2 САНХҮҮЖИЛТ

Эмэгтэйчүүдийн удирдсан бизнесүүд тогтвортой санхүүжилтгүй, хувийн хуримтлал болон албан бус эх үүсвэрт тулгуурласан “амьд үлдэх” стратегиар ажиллаж байгаа нь тэдний урт хугацааны өсөлт, тогтвортой байдлыг хязгаарлаж байна.

3 БҮТЦИЙН БЭРХШЭЭЛҮҮД

Санхүүжилт, зах зээл, технологи, сүлжээ зэрэг бүтцийн олон давхар хязгаарлалтаас шалтгаалан эмэгтэйчүүдийн бизнесүүд жижиг, эмзэг хэвээр үлдэж, эдийн засгийн цочролд өртөмтгий байна.

4 ДАРАМТ, ХҮЧИРХИЙЛЭЛ


Жендэрт суурилсан, ялангуяа эдийн засгийн хүчирхийлэл нь эмэгтэйчүүдийн санхүүгийн бие даасан байдал, бизнес эрхлэх эрх мэдлийг сулруулж, эдийн засгийн оролцоонд ноцтой саад болж байна.

5 ХАМГААЛЛЫН ТОГТОЛЦОО

Хүчирхийлэл, тусламж авах тогтолцооны сул байдал нь эмэгтэйчүүдийн бизнесийн тогтвортой байдал, өөртөө итгэх итгэлд сөргөөр нөлөөлж, эдийн засгийн чадавхижуулалтыг бүтцийн түвшинд хязгаарлаж байна.

Хэрэгжиж буй төсөл

ЗАХИАЛАГЧ, ХАМТРАГЧ, САНХҮҮЖҮҮЛЭГЧ



“Уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах болон жендэрийн мэдрэмжтэй бодлогоор дамжуулан хөдөөгийн эмэгтэйчүүд, охидын жендэрийн тэгш байдлыг сайжруулах нь” техник туслалцааны төсөл

Төслийн үндэслэл

IRIM судалгааны хүрээлэн Азийн Хөгжлийн Банк (АХБ)-ны санхүүжилтээр Жендэрийн Үндэсний Хороотой хамтран хэрэгжүүлж буй уг техникийн туслалцааны төслийг 2024-2026 оны хооронд хэрэгжүүлж байгаа билээ. Төслийн хүрээнд 2025 онд Үр дүн 2 болох Мэдлэг түгээх, Үр дүн 3 болох Чадавхжуулах арга хэмжээнүүдийг амжилттай хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- “Жендэрийн эрх тэгш байдал ба Уур амьсгалын өөрчлөлт” сэдэвт олон улсын хурал зохион байгуулах,
- “Жендэрийн бодлогоор уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах нь” сэдэвт бүсийн семинар зохион байгуулах,
- Бичил, жижиг бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг чадавхжуулах,
- Политехник коллежийн Мал амьтны эмнэл зүй, малын асаргаа хөтөлбөрт жендэрийн зөвлөмж боловсруулж хүлээлгэн өгөх ээрэг ажлуудыг хийж гүйцэтгэв.

Газар зүйн хамрах хүрээ

Гадаадын 8 улс, 11 олон улсын байгууллага, хөгжлийн түнш болон Монгол Улсын 21 аймгийг хамарсан.

Төслийн онцлох үр дүн

Олон улсын хурлын хүрээнд

2025 оны 5-р сарын 22-23-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулсан уг олон улсын хуралд Ази, Америк, Европ, Австрали тивийн 8 улсын засгийн газар, 11 олон улсын байгууллага, хөгжлийн түнш, иргэний нийгэм, эрдэмтэн судлаач, малчин, тариаланч, орон нутгийн 200 гаруй төлөөлөл оролцов. Хурлаар жендэрийн эрх тэгш байдал ба уур амьсгалын өөрчлөлтийн харилцан хамаарал, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй байгалийн гамшигт эрэгтэй, эмэгтэйчүүд хэрхэн өртөж, даван туулж буй хийгээд жендэрийн хариуцлагатай уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох бодлого, төлөвлөлт, санхүүгийн механизмын талаар олон талын мэдээлэл туршлага солилцож, уриалга гаргалаа. Энэхүү хурал нь Монгол Улсад 2026 онд зохион байгуулагдах “Цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын конвенцын Талуудын XVII бага хурал”-ыг угтаж, Жендэрийн үндэсний хороо байгуулагдсаны 30 жилийн ойн хүрээнд, “Биологийн олон янз байдлыг хамгаалах” олон улсын өдөр зохион байгуулагдсанаараа онцлог юм.

Олон улсын хурал



Бүсийн семинар



Бүсийн семинарын хүрээнд

Төслийн мэдлэгийн арга хэмжээний хүрээнд 21 аймгийг хамарсан бүсчилсэн семинарыг холбогдох мэргэжилтэн, малчин, тариаланч, бизнес эрхлэгчдийг хамруулан зохион байгуулсан. Семинарын оролцогчид 2026 онд зохион байгуулагдах бүсийн семинарт хийж хэрэгжүүлсэн сайн туршлагаа хуваалцах үүрэг амлалт авлаа.

Мөн Үр дүн 3-ын хүрээнд бичил, жижиг бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг чадавхжуулах зорилгоор 10 төсөл шалгаруулан тус бүр 5,000 ам.долларын буцалтгүй тусламж олгож, бодит ур чадвар олгох менторшип хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.

Түүнчлэн, Төв аймгийн Эрдэнэ сум болон Хэнтий аймгийн политехник коллежийн Мал амьтны эмнэл зүй, малын асаргаа хөтөлбөрт жендэрийн зөвлөмж боловсруулж хүлээлгэн өглөө. Ийнхүү тэдгээр политехник коллежийн мэргэжлийн хөтөлбөрийн багш нар уг зөвлөмжийг хичээлийн хөтөлбөртөө тусган ажиллаж байна.

Хэрэгжиж буй төсөл

ЗАХИАЛАГЧ, ХАМТРАГЧ, САНХҮҮЖҮҮЛЭГЧ



“Хуурамч мэдээлэлтэй тэмцэх замаар ардчилал, шударга ёсыг бэхжүүлэх нь” төсөл

Төслийн үндэслэл

Энэхүү төсөл нь Монгол болон Филиппин улсад хуурамч мэдээллийн тархалт ардчилсан үйл явц, иргэдийн институцэд итгэх итгэл, мэдээллийн орчны чанарт хэрхэн сөргөөр нөлөөлж буйг судалж, олон нийтийн түвшинд хуурамч мэдээлэлд сөрөн тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлэхэд чиглэсэн нэг жилийн хугацаатай хамтарсан санаачилга юм.

Үргэлжилсэн хугацаа

2025 оны 6 сараас 2026 оны 6 дугаар сар хүртэл.



Төслийн танилцуулга

2025 онд төслийн I шат болох хуурамч мэдээллийн нөхцөл байдлын зураглалын судалгааг хоёр улсад гүйцэтгэлээ. Үүнд, баримт бичгийн судалгаа, чанарын ярилцлага болон Монголд үйл ажиллагаа явуулдаг 2 баримт шалгах төвөөс авсан 1,618 мэдээ буюу хоёрдогч өгөгдөлд шинжилгээ хийсэн. Судалгаагаар:

- Монгол Улсад тархацтай хуурамч мэдээллийн гол сэдэв, түгээлтийн сувгууд, оролцогч талууд, ашиглагдаж буй арга техник,
- Хувь хүн болон нийгэмд үзүүлж буй нөлөөлөл,
- Хуурамч мэдээлэлтэй тэмцэх чиглэлээр талуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ зэргийг цогцоор нь тодруулсан.

Дараагийн шатанд иргэдийн мэдээлэлтэй харилцах зан үйл, хуурамч мэдээлэлд өртөх хэв маяг, эмзэг бүлгүүдийн онцлогийг нарийвчлан судлах олон нийтийн зан үйлийн судалгааг 2026 оны эхний улиралд гүйцэтгэж байна. Судалгааны үр дүнд тулгуурлан орон нутгийн иргэд, залуучуудад чиглэсэн олон нийтийн оролцоонд суурилсан интервенц, мэдээллийн боловсролыг нэмэгдүүлэх туршилтын үйл ажиллагаа хэрэгжүүлэх юм.

Төсөл нь хуурамч мэдээлэлтэй тэмцэх чиглэлээр иргэдийн оролцоо, шүүмжлэлт сэтгэлгээ, ардчилсан үнэт зүйлсийг бэхжүүлэхэд чиглэсэн тогтвортой, хүний эрхэд суурилсан шийдлүүдийг турших, хөгжүүлэхэд онцгойлон анхаарч байна.

Судалгааны дизайн, арга зүй

2025 онд төслийн I шат болох хуурамч мэдээллийн нөхцөл байдлын зураглалын судалгааг хоёр улсад гүйцэтгэлээ. Үүнд, баримт бичгийн судалгаа, чанарын ярилцлага болон Монголд үйл ажиллагаа явуулдаг 2 баримт шалгах төвөөс авсан 1,618 мэдээ буюу хоёрдогч өгөгдөлд шинжилгээ хийсэн. Судалгаагаар:

- Монгол Улсад тархацтай хуурамч мэдээллийн гол сэдэв, түгээлтийн сувгууд, оролцогч талууд, ашиглагдаж буй арга техник,
- Хувь хүн болон нийгэмд үзүүлж буй нөлөөлөл,
- Хуурамч мэдээлэлтэй тэмцэх чиглэлээр талуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ зэргийг цогцоор нь тодруулсан.

Төслийн мэдлэгийн арга хэмжээний хүрээнд 21 аймгийг хамарсан бүсчилсэн семинарыг холбогдох мэргэжилтэн, малчин, тариаланч, бизнес эрхлэгчдийг хамруулан зохион байгуулсан. Семинарын оролцогчид 2026 онд зохион байгуулагдах бүсийн семинарт хийж хэрэгжүүлсэн сайн туршлагаа хуваалцах үүрэг амлалт авлаа.

Монголд хамгийн түгээмэл тархаж буй хуурамч мэдээллийн сэдвүүд

Эрүүл мэнд

- Эрүүл мэндийн зөвлөгөө
- Вакцин
- COVID-19
- Хоол хүнс
- Хортой бараа
- Умайн хүзүүний хорт хавдрын эсрэг вакцин...

Нийгэм

- Эдийн засаг
- Байгаль орчин
- Олны танил
- Жендэр
- Улс төрчдийн талаар
- Хууль эрх зүй
- Гэмт хэрэг
- Осол...

Залилан

- Санхүүгийн залилан
- Хувийн мэдээллийн залилан
- Эрүүл мэндийн бүтээгдэхүүний залилан

Дотоод улс төр

- Улс төрчдийн үйл ажиллагааны тухай
- Сонгууль

Гадаад

- Олны танил
- Эдийн засаг
- Улс төрч
- Жендэр
- Байгалийн гамшиг
- Бусад...

Хуурамч мэдээллийн оролцогч талууд



Хуурамч мэдээллийг зөвхөн нэг хүн эсвэл нэг тал бүтээж, түгээдэггүй бөгөөд олон талууд ялгаатай байдлаар оролцож байна.

Оролцогч талууд өөрийн гэсэн үүрэг, сэдэл, уялдаа холбоо, тодорхой онцлог, хэв шинжтэйгээр хуурамч мэдээллийн экосистемд оролцдог.


Хуурамч мэдээлэл түгээж буй суваг, арга техникүүд



Хуурамч мэдээлэлд ашиглаж буй аргууд (n=1618)



Фэйсбүүкт хуурамч мэдээлэл түгж буй байдал



Хүлээгдэж буй үр дүн

Дараагийн шатанд иргэдийн мэдээлэлтэй харилцах зан үйл, хуурамч мэдээлэлд өртөх хэв маяг, эмзэг бүлгүүдийн онцлогийг нарийвчлан судлах олон нийтийн зан үйлийн судалгааг 2026 оны эхний улиралд гүйцэтгэж байна. Судалгааны үр дүнд тулгуурлан орон нутгийн иргэд, залуучуудад чиглэсэн олон нийтийн оролцоонд суурилсан интервенц, мэдээллийн боловсролыг нэмэгдүүлэх туршилтын үйл ажиллагаа хэрэгжүүлэх юм.



Хэрэгжиж буй төсөл

ЗАХИАЛАГЧ, ХАМТРАГЧ, САНХҮҮЖҮҮЛЭГЧ



Гэр бүлд ээлтэй ажлын байрны бодлогын хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдлын судалгаа



Төслийн танилцуулга

Монгол Улсад гэр бүлд ээлтэй ажлын байрны бодлого (ГБЭБ) нь хөдөлмөрийн харилцааны зохицуулалт, асаргааны тогтолцоо, хүүхдийн эрхийн хэрэгжилтийн огтлолцолд оршиж байна. Эцэг эх, асран хамгаалагчдын хөдөлмөр эрхлэх нөхцөл нь зөвхөн байгууллагын дотоод удирдлагын асуудал бус, хүүхдийн хамгаалал, хөгжлийн боломж, гэр бүлийн эдийн засгийн тогтвортой байдалтай шууд холбоотой. Энэхүү үнэлгээ нь байгууллагын түвшний институтийн бэлэн байдал, хөдөлмөрийн харилцааны зохицуулалт, ажилтны бодит туршлагыг нэгтгэн шинжилснээр гэр бүлд ээлтэй бодлого Монгол Улсад хэрхэн хэрэгжиж байгааг тодорхойлсон болно.

Хүүхдийн эрт үеийн хөгжил нь тогтвортой хайр халамж, хамгаалал, эрүүл мэнд, зохистой хоол тэжээл, хөгжлийг дэмжих өдөөлтөөс шууд хамаардаг бөгөөд энэ бүхэн нь цаг хугацаа, дэмжлэгтэй асаргаа шаарддаг. Гэвч Монгол Улсад олон эцэг эх, асран хамгаалагчид ажлын хуваарь нь ачаалал ихтэй, хүүхэд асрах үйлчилгээний боломж хязгаарлагдмал, гэр бүлийн хүрээнд хийгддэг цалингүй хөдөлмөрийн тэгш бус хуваарилалт байдаг зэрэг шалтгаанаар бага насны хүүхдэд шаардлагатай түвшний асаргаа үзүүлэхэд хүндрэлтэй тулгарч байна.

Төслийн арга зүй

Энэхүү судалгааны арга зүй нь Монгол Улсад гэр бүлд ээлтэй ажлын байрны бодлогын өнөөгийн байдал, хэрэгжилт, байгууллагын болон ажилтны түвшний нөлөөллийг цогцоор нь үнэлэх зорилгоор боловсруулагдсан.

Үүнд НҮБ-ын Хүүхдийн Сангаас бизнес эрхлэгчдэд зориулан боловсруулсан "Гэр бүлд ээлтэй бодлогын гарын авлага" (2020) болон "Building Family-Friendly Workplaces" (2025) зэрэг олон улсын арга зүйн баримт бичгүүд тулгуур болсон. Судалгаанд төр болон хувийн хэвшлийн нийт 50 байгууллага хамрагдаж, 1030 ажилтан асуумжид оролцлоо.



Аргачлал

- UNICEF, Бизнес эрхлэгчдэд зориулсан Гэр бүлд ээлтэй бодлогын гарын авлага, 2020
- UNICEF, Building Family Friendly Workplaces, 2025



Үнэлгээ

- Байгууллагын өөрийн үнэлгээ
- Ажилтнуудын хэрэгцээний үнэлгээ



Зөвлөмж

- Хэрэгжилтийн зөвлөмж



Хөдөлмөрийн харилцаа дуусгавар болсон шалтгаанд дүн шинжилгээ хийж буй байдал

52%

Гэр бүлд ээлтэй бодлогын үр нөлөөг үнэлж буй байдал

38%

Зарим онцлох үр дүнгээс


Гэр бүлд ээлтэй бодлогын чиглэлд системтэй дүн шинжилгээ хийх тогтолцоо бүрэн төлөвшөөгүй байна. Гэр бүлд ээлтэй бодлогын бодит үр нөлөөг баталгаажуулахын тулд олон түвшинд хяналт-шинжилгээний институцийн механизм бүрдүүлсэн байх шаардлагатай. Дараах үзүүлэлтүүд нь байгууллагуудын энэхүү институцийн чадавхын өнөөгийн түвшнийг илэрхийлж байна.

Гэр бүлийн асаргааны хэрэгцээнээс шалтгаалсан ажлын тасалдал нь ажилтнуудын хувьд тогтмол тулгардаг бодит нөхцөл байдал болж байна.

Өдөр тутмын ажлын тасалдал



Төрийн байгууллагын ажиллагсадтай харьцуулахад хувийн хэвшилд ажиллагсад ГБЭБ-ын хэрэгжилт ажлын сэтгэл ханамжид илүү эерэг нөлөөтэй гэж үнэлэх хандлагатай байна.



Бодлогын хэрэгжилтийн сэтгэл ханамжид судалгаа хийж буй байдал

36%

Үр нөлөөг үнэлэхдээ өгөгдлийг ангилж буй байдал

22%



Хэрэгжиж буй төсөл

ЗАХИАЛАГЧ, ХАМТРАГЧ, САНХҮҮЖҮҮЛЭГЧ

RioTinto

Сонгинохайрхан болон
Баянзүрх дүүргийн олон нийтийн
хэрэгцээг тодорхойлох судалгаа

Төслийн танилцуулга

Улаанбаатар хотод хотжилт хурдацтай явагдаж, орон сууц болон гэр хороолол холилдсон хотын захын томоохон дүүргүүдэд хөгжлийн ялгаа илүү тод илэрч байна. Ялангуяа амьжиргааны нөхцөл, үйлчилгээний хүртээмж, хөдөлмөр эрхлэлтийн боломж болон байгаль орчны чанарын хувьд мэдэгдэхүйц ялгаа ажиглагдаж буйтай холбогдуулан “Рио Тинто Монгол” ХХК-аас Баянзүрх болон Сонгинохайрхан дүүрэгт “Олон нийтийн хэрэгцээг тодорхойлох судалгаа”-г санаачлан хэрэгжүүлж байна.

Энэхүү судалгааны зорилго нь иргэдийн бодит хэрэгцээг нотолгоонд суурилан тодорхойлох, цаашид хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын санаачилгуудыг олон нийтийн бодит тэргүүлэх чиглэлүүдтэй уялдуулах, одоо хэрэгжиж буй арга хэмжээтэй давхардал үүсэхээс сэргийлэх, улмаар оршин суугчдын амьдралын чанар болон олон нийтийн тэсвэрлэх чадварыг сайжруулахад бодит хувь нэмэр оруулахад оршино.

Үргэлжилсэн хугацаа

2025.11.18 – 2026.04.08

Судалгааны дизайн, арга зүй

Үнэлгээний арга зүй нь олон нийтийн тэсвэрлэх чадвар (community resilience) болон сайн сайхан байдал (well-being)-ыг уялдуулсан дөрвөн үндсэн сэдвийн хүрээнд бүтэцлэгдсэн. Тус компанийн хэрэгжүүлэх аливаа олон нийтийн хөгжлийн санаачилгаас урт хугацаанд бодит үр нөлөө бий болгохын тулд тэсвэрлэх чадварыг суурь зарчим болгон тусгаж, нийгэмд тулгарч буй тодорхойгүй байдал болон уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдэлүүд нэмэгдэж буй нөхцөл байдлыг харгалзан үзсэн болно.

Энэ хүрээнд олон нийтийн төв (community hub)-ийн санаачилгуудыг (1) хариуцлагатай засаглал, (2) амьдралын чанар, (3) орон нутгийн хүчирхэг эдийн засаг (4) бэлэн байдал бүхий тогтолцоо гэсэн дөрвөн үндсэн хэмжигдэхүүний дагуур үнэллээ. Үүний зэрэгцээ олон нийтийн төвийн үр дүнтэй ажиллагаа болон урт хугацааны

тогтвортой байдлыг тодорхойлох итгэлцэл, оролцоо, нөөц боломж, нийгмийн сүлжээ зэрэг олон нийтийн түвшний хүчин зүйлсийг мөн харгалзан үзсэн болно.

Газар зүйн хамрах хүрээ

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нийт 5 хороо, Баянзүрх дүүргийн 4 хороо.

Төслийн хүлээгдэж буй үр дүн

Судалгааны үр дүнд Рио Тинто компанийн олон нийттэй харилцах бодлого стратегидаа авч хэрэгжүүлэх боломжтой, иргэдийн бодит хэрэгцээтэй уялдсан бодлогын зөвлөмж бүхий тайлан гарах юм. Түүнчлэн, төрийн болон хөгжлийн түншүүдийн санхүүжилттэй хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийг үнэлж, Рио Тинто компанийн оролцох боломжтой орон зай, цоорхойг тодорхойлно.

Хариуцлагатай засаглал

- Олон нийтийн төв (community hub) байгуулагдсанаар шийдвэрлэх боломжтой, орон нутгийн иргэд болон одоо үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын хоорондын итгэлцэл, хариуцлага, оролцоотой холбоотой гол зөрүү, сул талууд юу вэ?
- Ялангуяа төлөөлөл багатай бүлгүүдийн хувьд шийдвэр гаргах үйл явцад хүртээмжтэй, тогтвортой оролцоог хангахуйц байдлаар олон нийтийн төвийг (community hub) хэрхэн төлөвлөж, зохион байгуулах боломжтой вэ?

Амьдралын чанар

- Оршин суугчдын амьдралын чанарт хамгийн ихээр нөлөөлж буй хангагдаагүй хэрэгцээнүүд юу вэ? Ялангуяа эрүүл мэнд, орчны нөхцөл (үүнд бохирдол багтана), аюулгүй байдал болон нийгмийн сайн сайхан байдлын хүрээнд ямар асуудлууд илүү тулгамдаж байна вэ?
- Орон нутагт хүртээмжтэй олон нийтийн төвөөр дамжуулан ямар төрлийн үйлчилгээ болон олон нийтийн орон зайг бий болговол оршин суугчдын сайн сайхан байдалд урт хугацаанд хамгийн их эерэг өөрчлөлт авчрах боломжтой вэ?

Тогтвортой эдийн засаг

- Олон нийтийн дотор болон түүнээс гадна оршин суугчдын зохистой хөдөлмөр эрхлэлт, ур чадварын хөгжил, орлого бий болгох боломжуудад хүрэхэд ямар саад бэрхшээлүүд нөлөөлж байна вэ?
- Олон нийтийн төв нь оршин суугчдыг хөдөлмөр эрхлэх боломж, бизнес эрхлэлтийн дэмжлэг, мөн орон нутгийн нөөц боломжуудтай холбох замаар орон нутгийн эдийн засгийн тогтвортой, уян хатан байдлыг хэрхэн бэхжүүлэх боломжтой вэ?

Бэлэн байдлыг хангасан тогтолцоо

- Нийгэм, байгаль орчин, эрүүл мэнд болон эдийн засгийн ямар эрсдлүүд нь олон нийтийн тэсвэрлэх чадварт хамгийн их аюул занал учруулж байна вэ? Мөн эдгээр эрсдэлд хариу арга хэмжээ авахад одоогийн тогтолцоо хэр бэлтгэлтэй байна вэ?
- Нийгэм, байгаль орчин, эрүүл мэнд болон эдийн засгийн ямар эрсдлүүд нь олон нийтийн тэсвэрлэх чадварт хамгийн их аюул занал учруулж байна вэ? Мөн эдгээр эрсдэлд хариу арга хэмжээ авахад одоогийн тогтолцоо хэр бэлтгэлтэй байна вэ?

Хэрэгжиж буй төсөл

ЗАХИАЛАГЧ, ХАМТРАГЧ, САНХҮҮЖҮҮЛЭГЧ



Агаарын бохирдлыг бууруулах боломж, үр нөлөөний судалгаа

Төслийн танилцуулга

IRIM судалгааны хүрээлэн Дэлхийн банкны захиалгаар “Агаарын бохирдлыг бууруулах боломж, үр нөлөө”-ний суурь судалгааг 2025 оны 11 сараас 2026 оны 5 сарын хооронд хийж гүйцэтгэж байна. Уг суурь судалгааны зорилго нь Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд 2025-2026 онд гэр хорооллын өрхийн агаарын бохирдлыг бууруулах зорилгоор айл өрхүүдийг дулаалж, хийн халаагуур суурилуулах хөтөлбөрийн үр нөлөөг тодруулахад оршсон. Энэхүү судалгаа нь өвлийн улиралд агаарын бохирдлын түвшин хамгийн өндөр байдаг үед агаарын чанарыг сайжруулах, нийслэлийн иргэдийн эрүүл мэндийг хамгаалахад шаардлагатай чухал мэдээллийг бүрдүүлэх юм.

Суурь судалгааны мэдээлэл цуглуулалтын нэгдүгээр үе шатанд Чингэлтэй, Баянгол, Сүхбаатар, Сонгинохайрхан дүүргийн харьяа хороодын нийт 1,702 өрхөөс тоон судалгаа, 6 фокус бүлгийн ярилцлага болон хөтөлбөрт оролцогч талуудтай 20 ганцаарчилсан ярилцлага хийсэн. Хоёрдугаар үе шатанд дээрх 1700 өрхөөс 3-4-р сарын хооронд мэдээлэл цуглуулалтыг хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна.

Судалгааны гол үр дүн

Судалгаагаар өрхийн сууц дулаалгын туршлага, дулааны тав тух, дотоод агаарын чанар болон хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой гол хүчин зүйлсийг тодорхойлсон. Суурь судалгааны урьдчилсан үр дүнгээс харахад өрхийн сууц дулаалгын ажил хийгдсэний дараа хөтөлбөрт хамрагдсан өрхүүдийн 90 хувь нь гэрийн доторх орчин дулаахан, тав тухтай болсон гэж үнэлсэн. Энэ нь дулаалгын арга хэмжээ нь өрхийн дулааны нөхцөлийг сайжруулахад бодит нөлөө үзүүлж байгааг илтгэнэ.

Мөн хийн халаагуур суурилуулсны дараа туршилтын өрхүүдийн дотоод орчны PM2.5 тоосонцрын агууламж буурах хандлага

ажиглагдсан. Түүнчлэн цахилгаан халаалт, агаар цэвэршүүлэгч ашиглах зэрэг хэрэглээ нь дотоод орчны агаарын чанарыг сайжруулахтай холбоотой байгааг судалгааны үр дүн харуулж байна.

Өрхүүд хөтөлбөрт хамрагдах гол шалтгаанаар гэрээ илүү дулаан болгох, халаалтын зардлыг бууруулах, агаарын бохирдлыг багасгах зорилгыг дурдсан.

Харин хөтөлбөрт хамрагдаагүй өрхүүдийн хувьд хөтөлбөрийн талаар хангалттай мэдээлэлгүй байх, аюулгүй байдлын эрсдэлд санаа зовох зэрэг хүчин зүйлс оролцоонд нөлөөлсөн байна.


Хөтөлбөрт хамрагдсан шалтгаан




Хөтөлбөрөөс хүлээж буй үр дүн



Дотоод орчны агаарын чанарын өөрийн үнэлгээ



Дотоод орчны агаарын чанарын бодит үнэлгээ



PM 2.5



Хэрэгжиж буй төсөл

ЗАХИАЛАГЧ, ХАМТРАГЧ, САНХҮҮЖҮҮЛЭГЧ



“Төр-Хувийн хэвшил-Малчдын түншлэл-2026”

ХУВИЙН ХЭВШЛИЙН
ТҮНШЛЭЛ- 2026”

ҮЗЭСГЭЛЭН, АРГА ХЭМЖЭЭ



АДАПТ ТӨСӨЛ

Төслийн үндэслэл

Уур амьсгалын ногоон сангийн санхүүжилтээр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, НҮБХХ хамтран “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” төслийн 3-р бүрэлдэхүүн хэсэг буюу “Гарал үүсэл нь тогтвортой, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй мал аж ахуйн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх, малчдын чадавхыг нэмэгдүүлж, бэхжүүлэх” нь хэсгийн гүйцэтгэгчээр ажиллаж байна.

Төслийн үргэлжлэх хугацаа

2025 оны 11 дүгээр сараас 2026 оны 05 дүгээр сар хүртэл



Төслийн танилцуулга

Энэхүү төслийн хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэж байна.

1. Үндэсний болон орон нутгийн түвшний мал, мах, ноос ноолуур боловсруулах, бэлтгэх үйлдвэрүүдтэй зорилтот 4 аймгийн малчдын бүлэг, хоршоодын хооронд урт хугацааны, тогтвортой нийлүүлэлтийн гэрээ байгуулах үйл явцыг дэмжих.
2. Малчдын хоршоодод зориулсан сургалт зохион байгуулах
3. Зорилтот 4 аймаг тус бүрээс 1 малчдын бүлгийг сонгон “хариуцлагатай нүүдэлчин” стандартыг нэвтрүүлэхэд шаардлагатай суурь бэлтгэлийг хийх.

Дээрх ажлын хүрээнд малчдын хоршоодын чадавхыг бэхжүүлэх, тогтвортой нийлүүлэлтийн гэрээ байгуулах, зорилготой “Төр-хувийн хэвшил-малчдын түншлэл” арга хэмжээг Ховд, Завхан, Сүхбаатар, Дорнод аймгуудад зохион байгууллаа.

Төслийн зорилго, арга зүй

Энэхүү ажлын зорилго нь малчдын хоршоо, бүлгүүдийг чадавхжуулж, төр-хувийн хэвшил-малчдын хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар гарал үүсэл нь тодорхой, уур амьсгалд тэсвэртэй малын гаралтай бүтээгдэхүүнийг зах зээлд тогтвортой нийлүүлэх тогтолцоог бүрдүүлэхэд оршино.

Ингэснээр малчид бүтээгдэхүүнээ баталгаатай борлуулах, тогтвортой орлоготой болох боломжтойн зэрэгцээ боловсруулах үйлдвэрүүд малчдаас түүхий эдээ урт хугацаанд шаардлагад нийцсэн байдлаар шууд авах нөхцөл бүрдэнэ.

Зарим онцлох үр дүнгээс

Төр-хувийн хэвшил-малчдын түншлэл арга хэмжээнд аймаг тус бүрд 50 малчдын хоршоо, Улаанбаатар хотоос ноос, ноолуур, мах боловсруулах чиглэлийн үндэсний 10 гаруй үйлдвэр, аж ахуйн нэгжийн төлөөлөл, орон нутгийн үйлдвэрүүд, аймгийн Засаг даргын Тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газрын алба хаагчид оролцож, цаашдын хамтын ажиллагааны талаар хэлэлцэн, гэрээ байгууллаа.



СУРГАЛТ -
Мэдлэг мэдээлэл олгох

Малын гаралтай бүтээгдэхүүний стандарт, гарал үүслийн баталгаажуулалт зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, хоршооны татварын сургалт нийтдээ 250 малчдад оров.



ГЭРЭЭ - Хамтын ажиллагааны гэрээ

Нийтдээ 4 аймагт мах болон ноолуурын чиглэлийн үндэсний болон орон нутгийн 80 хоршоодтой 172 хамтын ажиллагааны гэрээ байгуулагдлаа. Энэхүү гэрээг аймгуудын хүнс хөдөө аж ахуйн газар баталгаажуулж байгаа бөгөөд, бодит ажил хэрэг болоход нь анхаарч ажиллах юм.



СТАНДАРТ -
Хариуцлагатай нүүдэлчин стандарт

Зорилтот 4 аймгаас тус бүр нэг хоршоодыг сонгон, хариуцлагатай нүүдэлчин стандартыг нэвтрүүлэх бэлтгэх ажлын хүрээнд хоршоодын үнэлгээг хийж, бэлтгэх ажлуудыг эхлүүлэв.

